

**Улаанбаатар хотын
Цэвэр агаарын санаачлага 2-р үе**

Байгаль орчин, ногоон хөгжлийн яам/ЕСБХБ

**Евроконсалт Мотт МакДоналд
Ногоон Хөгжлийн Хөтөч ТББ
Монголиан Барристерс & Солиситорс ХХК**

2013 оны 1-р сар



Улаанбаатар хотын цэвэр агаарын санаачлага 2-р үе

Гэрээний дугаар: 22384/EBSF2009-09-117/01

Цэвэр түлшний хөтөлбөрийн хүрээнд албадан хэрэгжүүлэх стратеги ба сургалт (3.6.1-3.6.3)

Огноо: 2013 оны 1-р сар

Байгаль орчин, ногоон хөгжлийн яам
ЕСБХБ

БОНХЯ
Засгийн газрын II байр
Нэгдсэн үндэстний гудамж 5/2
Улаанбаатар -210646
Монгол улс

ЕСБХБ
One Exchange Талбай,
Лондон хот, EC2A 2JN,
Их Британи

Issue and revision record

Шинэчилсэн	Огноо	Боловсруулсан	Шалгасан	Баталсан	Тайлбар
1	2012.12.31	Онно ван ден Хөувел Бүрэнбаяр Цэцэнбилэг Галсан Сурахбаяр	Пиет де Вилдт Доржсүрэн Эрдэнэ Дэвээ Энхээ Сузанне Рулофс		
2	2013.1.14	Онно ван ден Хөувел	Пиет де Вилдт		
3	2013.2.13	Онно ван ден Хөувел	Пиет де Вилдт		
4	2013.2.19	Онно ван ден Хөувел	Пиет де Вилдт		

Улаанбаатар хотын цэвэр агаарын санаачлага 2-р үе

Улаанбаатар хотын гэр хороололд уламжлалт зууханд чанар муутай түүхий нүүрс түлэх нь ялангуяа өвлийн саруудад хотын агаарын бохирдлын гол эх үүсвэр болж байна. Хотын агаарын чанар нь нийслэлийн оршин суугчдын эрүүл мэнд цаашлаад улс орны эдийн засагт сөргөөр нөлөөлж байна. Иймд уламжлалт зуухыг утаа бага ялгаруулдаг зуухаар солих, түүхий нүүрсийг боловсруулсан, утаа бага ялгаруулдаг, хэмнэлт сайтай түлшээр солих нь тулгамдаад байгаа агаарын бохирдлын асуудлын нэлээд хэсгийг богино хугацаанд шийдвэрлэх үр дүнтэй арга хэмжээний нэг гэж үзэх болсон. Боловсруулсан түлшний найдвартай нийлүүлэлт, түлш, зуухыг хослуулах, тэдгээрийг дэмжсэн орчин, стандартуудыг батлан гаргах нь уг арга хэмжээг үр дүнтэй явуулахад зайлшгүй шаардлагатай. Засгийн газар боловсруулсан түлшний хэрэглээнд шилжих үйл ажиллагааны тодорхой хэсэгт дэмжлэг үзүүлэхийг Европын сэргээн босголт, хөгжлийн банкнаас (ЕСБХБ) хүссэн юм. ЕСБХБ Монгол улсын Засгийн газартай 2008 оны 9-р сараас боловсруулсан түлшний хэрэглээнд шилжих төлөвлөгөөг боловсруулахаар хамтран ажиллаж эхэлсэн. Уг төлөвлөгөөний гол хэсгүүдийг 2009 оны 6-р сард Засгийн газраар батлуулахаар өргөн барьсан “Түлш солих үйл ажиллагааны ерөнхий бүдүүвч” баримт бичигт тусгасан. Засгийн газар Үйл ажиллагааны бүдүүвчийн гол бүрэлдэхүүн хэсгүүдийг зарчмын хувьд баталж, 2010 оны 6-р сард Монгол Улсын их хурал Агаарын багц хуулиудыг баталж гаргасаны дараа тус банк төслийн II үеийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр болж “Түлш солих үйл ажиллагааны ерөнхий бүдүүвч” баримт бичгийн гол хэсгүүдийг хэрэгжүүлэхэд Засгийн газарт дэмжлэг үзүүлэх Зөвлөх шалгаруулж авах ажлыг гүйцэтгэсэн. Зөвлөх нь Үйл ажиллагааны ерөнхий бүдүүвчийн холбогдох хэсгүүдийг хэрэгжүүлэхэд Засгийн газарт хууль эрх зүй, эдийн засаг, техникийн болон чадавхийг бэхжүүлэх зэрэг шаардлагатай бүхий л тусламж дэмжлэг үзүүлэх зорилготой.

УДИРТГАЛ	8
1 ЦЭВЭР ТҮЛШИЙГ ТҮГЭЭХ, ХЭРЭГЛЭХ АЖИЛЛАГААНД АЛБАДЛАГЫН АРГА ХЭМЖЭЭ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТУХАЙ ОЙЛГОЛТ	10
2 БОЛОВСРУУЛСАН ТҮЛШНИЙ ТҮГЭЭЛТТЭЙ ХОЛБОГДОХ ЖУРАМ, ГЭРЭЭНҮҮДИЙН ХЭРЭГЖИЛТ	12
2.1 <i>Боловсруулсан түлшний ханган нийлүүлэх ажиллагааг зохицуулж буй эрх зүйн актууд</i>	12
2.2 <i>Боловсруулсан түлшний үндэсний стандартуудын хэрэгжилт</i>	12
2.3 <i>Түгээлтийн тасалдал болон бүрэн бус нийлүүлэлт</i>	13
2.4 <i>Иргэний хуультай зөрчилдсөн зохицуулалт</i>	14
2.5 <i>Сав баглаа</i>	14
2.6 <i>Боловсруулсан түлшний ханган нийлүүлэлттэй холбоотой маргааныг шийдвэрлэх</i>	14
2.6.1 <i>Маргаан шийдвэрлэх</i>	14
2.6.2 <i>Шүүхээр маргааныг шийдэх ба хохирлыг барагдуулах</i>	15
3 АГУУЛАХТАЙ ХОЛБОГДОХ АЛБАДЛАГЫН АРГА ХЭМЖЭЭ	17
3.1 <i>Эрх зүйн орчин</i>	17
3.2 <i>Албадлагыг арга хэмжээг хэрэгжүүлэх хууль зүйн өнөөгийн боломж</i>	17
3.2.1 <i>Агуулахад тавигдах шаардлага</i>	17
3.2.2 <i>Хадгалагдаж буй түлшний харуул хамгаалалт, аюулгүй байдал</i>	17
3.2.3 <i>Маргаан шийдвэрлэх</i>	18
4 ТЭЭВЭРЛЭЛТТЭЙ ХОЛБООТОЙ АЛБАДЛАГЫН АРГА ХЭМЖЭЭ	19
4.1 <i>Боловсруулсан түлш тээвэрлэх ажиллагааг зохицуулж буй эрх зүйн актууд</i>	19
4.2 <i>Хэрэгжилтийг хангах эрх зүйн боломж</i>	19
4.2.1 <i>Тээвэр хийх автомашинд тавигдах шаардлага</i>	19
4.2.2 <i>Тээвэрлэлтийн явцад бараа гэмтэх, гээгдэх, чанараа алдах</i>	19
4.3 <i>Хэрэгжилтийг шалгах</i>	20
4.4 <i>Маргаан шийдвэрлэх арга хэмжээг хэрэгжүүлэх</i>	20
4.4.1 <i>Харилцан тохиролцож маргаан шийдвэрлэх</i>	20
4.4.2 <i>Шүүхээр маргаан шийдвэрлэх</i>	21
5 ЖИЖИГЛЭН БОРЛУУЛАХТАЙ ХОЛБООТОЙ АЛБАДАН ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ	22
5.1 <i>Боловсруулсан түлш борлуулах ажиллагааг зохицуулж буй эрх зүйн актууд</i>	22
5.2 <i>Болзошгүй зөрчил</i>	22
5.3 <i>Хэрэгжилтийг хангах эрх зүйн боломж</i>	22
5.3.1 <i>Жижиглэн борлуулагчдад тавигдах шаардлага</i>	22
5.3.2 <i>Борлуулагчийн учруулсан хохирлыг төлүүлэх</i>	22
5.4 <i>Ваучер болон санхүүтэй холбоотой асуудал</i>	23
5.5 <i>Маргаан шийдвэрлэх арга хэмжээг хэрэгжүүлэх</i>	23
5.5.1 <i>Маргаан шийдвэрлэх</i>	23
6 ТҮҮХИЙ НҮҮРС, ХОГ ХАЯГДАЛ ТҮЛЭХИЙГ ХОРИГЛОХ ТУХАЙ	24
6.1 <i>Эрх зүйн орчин</i>	24
6.2 <i>Хөтөлбөрийн дизайн</i>	24
6.3 <i>Мэдээлэл сурталчилгаа</i>	25
6.4 <i>Нийцлийн мониторинг</i>	25
6.5 <i>Хяналт шалгалт, торгууль шийтгэл</i>	26
7 АЛБАДЛАГЫН СТРАТЕГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ	28
8 СУРГАЛТ	29
8.1 <i>Сургалтын бэлтгэл ажил</i>	29

8.2	Сургалтын агуулга	29
8.2.1	Олон улсын туршлага	30
8.2.2	Албадлагын талаарх ерөнхий ойлголт сэдвийн хүрээнд	30
8.2.3	Боловсруулсан түлш нийлүүлэх.....	30
8.2.4	Боловсруулсан түлш хадгалах.....	31
8.2.5	Боловсруулсан түлшний тээвэрлэлт	31
9	ХАВСРАЛТ.....	32
	ХАВСРАЛТ 1: Холбогдох эрх зүйн актын нэрс	33
	ХАВСРАЛТ 2: СУРГАЛТЫН ИЛТГЭЛҮҮД	34
	ХАВСРАЛТ 3: НЭМЭЛТ МЭДЭЭЛЭЛ.....	38

Товчилсон үгс

ЦАС
ЕСБХБ
БОНХЯ
УБЦАС II

Цэвэр агаар сан
Европын сэргээн босголт, хөгжлийн банк
Байгаль орчин, ногоон хөгжлийн яам
Улаанбаатар хотын цэвэр агаарын санаачлага II үе

Удиртгал

Улаанбаатар хотын агаарын бохирдол нь үндэсний болон эрүүл мэндийн стандартын зохих түвшингээс их хэмжээгээр илүү байгаа нь хотын хүн амын эрүүл мэндэд үлэмж хортойгоор нөлөөлж байгаа билээ. Тиймээс Монгол Улсын Засгийн газар нь хотын агаарын чанарыг сайжруулах зорилгоор богино хугацааны шийдлүүдийн нэг болох гэр ахуйн халаалтын хэрэгсэлд түүхий нүүрс ашиглахыг хориглож, ойрын жилүүдэд багтаан боловсруулсан түлшээр орлуулах арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Айл өрхүүдийн зуухнаас үүсэж буй агаарын бохирдол (нарийн ширхэгт тоос_{2.5}) нь нийт агаарын бохирдлын 59¹ хувийг бүрдүүлж байна. Засгийн газраас Баянгол дүүргийн 12000 айл өрхийг боловсруулсан түлшээр хангах хөтөлбөрийг 2010 онд хэрэгжүүлж эхэлсэн. Энэхүү ажлын хүрээнд үйлдвэрлэгч, тээвэрлэгч, агуулах, борлуулагч нарыг гэрээлэн ажиллаж байна. Хөтөлбөр хэрэгжүүлж буй газар нутагт түүхий нүүрсний хэрэглээг албан ёсоор хориглосон бөгөөд оршин суугчид түлшнийхээ хэрэгцээг хагас коксжсон нүүрс, хагас коксон шахмал түлш, үртсэн шахмал түлшээр хангаж байна.

Хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэхийн тулд бүх гэрээлэгч талууд мөн тухайн бүсийн иргэд нь тодорхой хууль тогтоомж, журмууд, гэрээт үүргээ даган биелүүлэх нь нэн чухал юм. Засгийн газар цаашид энэхүү түүхий нүүрсний хязгаарлалтын бүсийг өргөтгөх зорилго тавьж байгаа боловч хэрхэн хэрэгжүүлэх нь өнөөдөр тодорхой бус байна.

УБ Цэвэр агаарын санаачлага-2 төслийн “Түлш орлуулах үйл ажиллагааны хүрээ” баримт бичгийн дагуу энэхүү стратеги нь цэвэр түлш хэрэглэх мөн түгээлтийн системийг албадан хэрэгжүүлэх ажилд дэмжлэг үзүүлэхэд чиглэгдсэн. Энэ судалгаа нь өнөөгийн эрх зүйн хүрээнд нийлүүлэлтийн сүлжээнд гарч байгаа зөрчлүүдийг тодорхойлох, тэдгээр зөрчлийг хэрхэн шийдвэрлэх талаарх хуульд заасан албадлагын арга хэмжээг боловсруулах зорилго бүхий судалгаа юм. **Мөн ажлын даалгаварт заасан оролцогч талуудад үзүүлэх дэмжлэг үзүүлэн холбогдох сургалтыг явуулсан ба энэ ажлын үр дүнг энэхүү тайланд хавсаргасан.**

Түүхий нүүрсний хязгаарлалтын бүсийн зохицуулалт, хог шатаах явдал мөн цэвэр түлшний түгээлтийн менежменттэй холбогдох бүхий л ажлын хэрэгжилтийг хянах, мониторинг хийх цогц бүтцийг боловсруулж, үүнийг хэрэгжүүлэхэд өнөөгийн эрхзүйн орчинд сайжруулах шаардлагатай байгаа зүйлсийг илрүүлж энэ баримт бичигт тусгалаа. Түүнчлэн цэвэр түлшний хөтөлбөрийн хүрээнд дэх албадан хэрэгжүүлэх ажилд мэдээлэл, сурталчилгааны ажлын үүрэг их байх ёстой.

Дараах гол арга хэмжээнүүд нь энэхүү стратегид багтсан. Үүнд:

Боловсруулсан түлшний чанарын асуудал

- 1а Чанарыг шалган хянах, мониторингийн мэдээллийн сан байгуулж хөтлөх
- 1б Гэрээнд ханган нийлүүлэгч талд нарийвчилсан шинжилгээ тест хийлгэх шаардлага тавих

Хуваарийн дагуу, гэрээнд заасан хэмжээний түлш нийлүүлэх

- 2а Нийлүүлж буй түлшний хувь хэмжээний талаар мэдээллийн сан байгуулах
- 2б Гэрээнд ханган нийлүүлэгч талд тавигдах торгуулийг илүү тодорхой тусгах
- 2в Гэрээнд ханган нийлүүлэгч талын дагаж мөрдөх хууль, журмыг оруулах
- 2г Савлагаа боодлын стандартыг шинэчлэн боловсруулах

¹Улаанбаатар дахь агаарын бохирдол – Суурь судалгаа (Дэлхийн банк) 2009.

2д Холбогдох талуудын хооронд үүсч болзошгүй маргаан, зөрчлийг шийдэх журам боловсруулах

Боловсруулсан түлшний агуулах

3 Агуулахуудыг хянан шалгах тодорхой шаардлагуудыг заах, түлшийг аюулгүй хадгалах талаарх журам боловсруулах

Түлшний тээвэрлэлт

4 Түлшний тээвэрлэлтийн үеийн шаардлагыг заасан журам боловсруулах

Түлшний борлуулалт

5 Түлш борлуулах цэгт хадгалах, худалдаалах журам боловсруулах

Түүхий нүүрс, хог хаягдал шатаахыг хориглох тухай

6а Түүхий нүүрсийг бүрэн хориглох зорилгоор үйлдвэрлэгчдийн хүчин чадлыг бодитойгоор тооцож, хязгаарлалтын бүсийг тогтоох

6б Дугуй, хуванцар зэрэг хог хаягдлыг шатааснаас хүний эрүүл мэндэд үүсэх хор холбогдлын талаарх мэдээлэл, сурталчилгааг гэр хорооллын иргэдэд хүргэх

6в Хог хаягдал түлэх явдлыг бүрэн хорьсон хууль тогтоомж гаргах

6г Хязгаарлалтын бүсэд цэвэр түлш хүрэлцээтэй болсны дараа түүхий нүүрс, хог хаягдал шатаах хоригийн хэрэгжилтийг хянан шалгаж, зөрчил гаргасан айл өрхийг торгох арга хэмжээ авч хэрэгжүүлэх

УБ Цэвэр агаарын санаачлага төслийн ажлын даалгаварт цэвэр түлшний хөтөлбөрийн албадан хэрэгжилтийг хангуулах баг байгуулах тухай заасан байна. Монгол улсад хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах үүрэг бүхий тогтсон бүтэц ажиллаж байна. Тиймээс энэ тайлангаар одоо байгаа энэ бүтэц нь цэвэр түлшний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулахын тулд хэрхэн ажиллаж болох талаар авч үзсэн болно.

1 Цэвэр түлшийг түгээх, хэрэглэх ажиллагаанд албадлагын арга хэмжээ хэрэгжүүлэх тухай ойлголт

Хүснэгтэнд заасанчлан албадлагын арга хэмжээний талаар олон төрлийн тайлбар ойлголт бий. Албадлагын арга хэмжээ гэдэг нь ерөнхийдөө байгууллага болон хүн хууль ёсийг хэрэгжүүлэх ойлголтыг хэлдэг.

Энэхүү сртатеги нь Улаанбаатар хотын гэр хороололд боловсруулсан түлшийг нэвтрүүлэхэд албадлагын арга хэмжээг хэрхэн хэрэглэх тухай заасан. Энэхүү судлагааны хүрээнд ханган нийлүүлэлт, түгээлт, хадгалалт, борлуулалт, ашиглалт зэрэг боловсруулсан түлшний хөтөлбөрийн бүхэл үе шатыг хамрууллаа. Түүнчлэн боловсруулсан түлшний хувьд хагас коксжсон нүүрс болон шахмал түлш мөн шахмал үртсэн түлшний нийт гурван гол стандарт бий. Тэдгээрийн хэрэгжилт ч энд яригдах болно.

Албадлагын арга хэмжээний үндсэн тулгуур зарчмууд дээр үндэслэн энэ сртатегийг боловсруулав. Эдгээрт:

1. Эрх зүйн зохистой орчин бүрдсэн байх нь нэн тэргүүнд тавигдах гол шаардлага юм. Эрх зүйн орчинд ямар нэгэн хийдэл байвал албадан хэрэгжүүлэх ажилд хүндрэл учирдаг бөгөөд зарим тохиолдолд хэрэгжүүлэх ч боломжгүй болно. Тиймээс боловсруулсан түлштэй холбоотой харилцааг зохицуулж буй өнөөгийн хууль зүйн орчинд дүн шинжилгээ хийж сайжруулах талаар санал дүгнэлтийг гаргалаа.
2. Үйлдвэрлэгч, тээвэрлэгч, хэрэглэгч зэрэг гол оролцогч талуудад явуулах олон нийтийн мэдээлэл, сурталчилгааг сайжруулах шаардлагатай. Боловсруулсан түлшний давуу талууд түүнчлэн түүхий нүүрс болон элдэв хог хаягдал түлэх нь иргэдийн эрүүл мэндэд ямар хортойг гэр хорооллын иргэдэд бүрэн дүүрэн ойлгуулах ёстой.
3. Холбогдох хууль тогтоомж, гэрээний заалтын хэрэгжилтийг хангуулах Хяналт, мониторингийн системийг боловсруулах. ЗГ нь эдгээр хууль, тогтоомж, журмын хэрэгжилт хэр байгааг нягталж байхын тулд системтэй мэдээллийн санг байгуулах хэрэгтэй.
4. Холбогдох хууль тогтоомжийг дагаж мөрдүүлэх тодорхой механизмууд тусгагдсан. Энэ хүрээнд маргаан зөрчлийг зохицуулах арга замыг орууллаа.

Албадлагын арга хэмжээ гэдэг нь хууль ёсны эрх бүхий институци хуулийг хэрэгжүүлэх ойлголтыг хэлнэ.

*J. Kleinfeld,
The Yale Law Journal, 2011.*


Хуулийн албадлагын арга хэмжээ гэдэг нь нийгмийн зарим гишүүд зохион байгуулалттайгаар тэрхүү нийгмийг зохицуулж байгаа дүрэм журам, хэм хэмжээг зөрчсөн этгээдүүдийг илрүүлэн шийтгэх ойлголтыг хэлнэ. Хэдийгээр энэ нэр томъёо нь шүүх, хорих байгууллагуудад мөн адил хамаардаг ч хууль хэрэгжүүлэх байгууллагын байцаагч болон эрүүгийн гэмт хэргийн хүрээнд мөрдөн байцаах, шалгах чиг үүргийг хэрэгжүүлэгч этгээдэд бас хамаардаг ойлголт болно.

Wikipedia, December 2012

Цэвэр түлшний хөтөлбөрийн хүрээнд хэрэгжилтийг нь хангуулах дараах хууль тогтоомжууд байна. Үүнд:

1. Монгол улсын Боловсруулсан, шахмал түлшний стандартууд
2. Цэвэр түлш түгээх хөтөлбөрийн хүрээнд гарсан тогтоол, захирамж, шийдвэрүүд
3. Нийлүүлэгч, тээвэрлэгч, борлуулагчийн гэрээ
4. Агаарын чанар сайжруулах үндсэн бүсэд түүхий нүүрс (боловсруулсан түлшний нийлүүлэлт хангалттай болсон тохиолдолд), хог хаягдал түлэх, шатаахыг хориглосон хориг

Албадан хэрэгжүүлэх ажлын схемчилсэн загварыг Зураг 1 –т үзүүлэв.



Зураг 1 Албадлагын стратегийн үндсэн үе шат

ЦАС нь хууль тогтоомжийг албадан хэрэгжүүлэх үүрэгтэй байгууллага биш тул энэ тайлан нь хөтөлбөрийн хүрээнд хууль тогтоомжийн хэрэгжилт хангуулах асуудлаар ЦАС холбогдох албадтай ажиллах, эдгээр байгууллагын авч явуулсан ажлын үр дүнд дүн шинжилгээ хийхэд нь дэмжлэг болох юм.

ЦАС-гийн ажилтнуудын энэ чиглэлээрх чадавхийг дээшлүүлэхийн тулд хяналт шалгалтын байгууллагуудаас явуулдаг хууль тогтоомжийн нийцлийн мониторингийн талаар сургалт зохион байгууллаа.

2 Боловсруулсан түлшний түгээлттэй холбогдох журам, гэрээнүүдийн хэрэгжилт

Боловсруулсан түлшний түгээлтийн систем нь үйлдвэрлэл ба ханган нийлүүлэлтээс эхэлдэг. Энэ шатанд ханган нийлүүлэгчид нь түлшний стандартуудын илчлэг, үнслэг, хүхэрлэг зэрэг үзүүлэлтийг зохих заагдсан түвшинд сахин мөрдөж хэрэглэгч иргэдэд аливаа хүндрэлийг ашиглалтын явцад гаргах ёсгүй. Тэд мөн агаарын бохирдлыг бууруулахын тулд ханган нийлүүлэлтийн хувь хэмжээ, хуваарийг чандлан мөрдөж иргэдэд түүхий нүүрс мэтийн бохирдуулагч түлш хэрэглэхээс аргагүй байдалд хүргэхгүй байх нь нэн чухал билээ.

2.1 Боловсруулсан түлшний ханган нийлүүлэх ажиллагааг зохицуулж буй эрх зүйн актууд

Доорхи эрхзүйн актууд түлшний ханган нийлүүлэлтийг зохицуулж байна:

- 2012 онд шинэчлэгдсэн Агаарын тухай хуулиар түүхий нүүрсний хязгаарлалтын бүсийг тогтоох, хог хаягдал түлэхийг хориглох зэрэг эрхзүйн зохицуулалт бий болсон билээ.
- Хагас коксжсон нүүрс болон хагас коксжсон шахмал түлшний хоёр стандарт байдаг. Шахмал түлшний стандартад үртсэн шахмал түлшинд тавигдах шаардлагуудыг хамтатган тусгасан байдаг. Манай төсөл Эрчим хүчний яам болон Үндэсний стандарчилал хэмжилзүйн төвтэй хамтран уг стандартуудыг сайжруулахаар ажиллаж байна. Үр дүнг нь тусдаа тайлангаар танилцуулна.
- Цэвэр түлшний хөтөлбөрийг зохицуулж буй дараах журмууд байна. Үүнд:
 - Боловсруулсан түлшийг нийлүүлэх харилцаа нь Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2011 оны 09 дугаар сарын 07-ны өдрийн 131 тоот тогтоолоор баталсан “Боловсруулсан түлш нөөцлөх, дүүрэг, хороо, иргэдэд хүргэх журам”-р шууд зохицуулагдана.
 - “Агаарын чанарыг сайжруулах бүс дэх түүхий нүүрсийг хязгаарлах үндсэн бүсэд орших айл өрхийг боловсруулсан түлшээр хангах нөөц бүрдүүлэхтэй холбогдуулан урьдчилгаа санхүүжилт олгох тухай журам” мөн батлагдсан байна.
- Мөн зохих хууль тогтоомжийн дагуу нэг талаас санхүүжүүлэгчийг төлөөлж “Цэвэр агаар сан”, захиалагчийг төлөөлж “НЗДТГ” (цаашид “Захиалагч” гэх), нөгөө талаас боловсруулсан түлш нийлүүлэгч аж ахуйн нэгж нарын хооронд “Боловсруулсан түлшний нөөц бүрдүүлэхтэй холбогдуулан түлш нийлүүлэх, түүнийг урьдчилан худалдан авах” гэрээг байгуулдаг.

2.2 Боловсруулсан түлшний үндэсний стандартуудын хэрэгжилт

Түлшинд тавигдах MNS 5679; 2011 стандарт батлагдсан байна. Эдгээр стандартууд нь голлох таван үзүүлэлтийг хангахыг шаарддаг. Өвлийн цагт илчлэг сайтай түлшнээс гэрийн дулаан шалтгаалдаг тул эдгээр стандартын шаардлагыг албадан хангуулах шаардлагатай. Нийлүүлэгч байгууллагын нийлүүлж буй түлш нь дээрх стандартад нийцэж байгаа эсэхэд НАЧА хяналт тавих ба мөн нийслэлийн болон улсын МХЕГ эдгээр түвшинд шинжилгээ хийх эрхтэй. Гэвч шинжилгээ хэдий хэмжээнд явагдах нь түлш стандартын шаардлагыг хангаж буй эсэхийг тогтоох чадвартай итгэмжлэгдсэн лабораторийн хүрэлцээнээс хамаарч байна.

Тийм лаборатори хүрэлцээгүй байвал түлшний шалгалт нь нийлүүлэлтийн хэмжээ, цагийн хуваарийг хянахаас хэтрэхгүй болно.

Гэрээний зохицуулалтаар өнөөдөр зөвхөн ханган нийлүүлэгч өөрөө шинжилгээ хийлгэж үр дүнгээ НАЧА-д мэдээлэх үүрэгтэй. НАЧА нь түлшний чанарыг шинжлүүлэх үүрэгтэй боловч шинжилгээг ямар давтамжтайгаар яаж явуулах нь тодорхойгүй байна. Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хуулинд бүтээгдэхүүний чанар стандартад нийцсэн эсэхийг үйлдвэрлэгчээс хараат бус хөндлөнгийн итгэмжлэгдсэн лаборатори тогтоож, гэрчилгээ олгохоор заажээ. Сайжруулсан стандартын нэг хэсэг нь болох журманд НАЧА (эсвэл МХЕГ) нь нийлүүлэгчид, борлуулагчдаас түлшний дээж цуглуулан шинжлүүлэх, мөн дээжийг хэрхэн шинжлэх талаар нарийвчлан тусгах шаардлагатай. Шинжилгээний давтамжийг ч стандартад нарийвчлан тусгах ёстой. Шаардлагатай тохиолдолд шинжилгээний дүнг ЦАС, Хотын захирагчийн албанд тайлагнаж болно. Хүйтний улирал эхлэхээс өмнө нийлүүлэгчидтэй уулзалт хийж, мөрдөгдөх журам, стандартуудыг танилцуулан, тэдний гэрээгээр хүлээх үүргийг тодорхой болгох хэрэгтэй.

Албадлагын арга хэмжээг амжилттай хэрэгжүүлэхийн тулд холбогдох хууль, тогтоомж, гэрээний тодорхой заалтуудад нэмэлт өөрчлөлт оруулах хэрэгтэй байна. Тэдгээрт:

- Агаарын тухай хуулийн дагуу НАЧА нь түлшний стандартыг хэрэгжүүлэхэд гол үүрэг гүйцэтгэнэ гэж заасан. Тиймээс нийлүүлэгчтэй байгуулсан гэрээний 4.3-т “Аж ахуйн нэгжүүдээс түлшний шинжилгээний дүнг НАЧА шаардаж авах эрхтэй.” гэж заажээ. Түлшний чанарын талаар хангалттай мэдээлэлтэй байхын тулд компаниуд шинжилгээнийхээ дүнг тогтмол хугацаанд ирүүлдэг байх шаардлагыг гэрээнд нь тусгаж өгөх нь зүйтэй. Нийлүүлэгчийн гэрээнд түлшний шинжилгээнд тавигдах шаардлагууд, мөн тухайн түлшинд хийсэн шинжилгээ нь стандартад нийцээгүй тохиолдолд түлшийг хүлээн авахгүй байх талаарх заалтуудыг оруулах нь чухал юм.
- Боловсруулсан түлшний шинжилгээг ямар лаборатори явуулах эрхтэйг мөн нарийвчлан заах хэрэгтэй байна. Хуулиар зөвхөн итгэмжлэгдсэн лаборатори ийм шинжилгээ явуулахаар заасан байгаа тул гэрээнд мөн ингэж тусгах шаардлагатай.

Хэрэв компаниуд худал мэдээлэл ирүүлсэн нь тогтоогдвол 200,000-250,000 төгөгөөр торгохоор заасан байна. Харин хуулинд нийцэхгүй шинжилгээний дүн ирүүлсэн нь тогтоогдвол 100,000-150,000 төгрөгний торгуультай. Ийм зөрчлийн учруулах сөрөг үр дагаварт нь ойртуулах үүднээс торгуулийн хэмжээг өөрчлөх шаардлагатай. Ийм хэмжээний торгууль нь зөрчлөөс сэргийлэх хэмжээний нөлөө үзүүлж чадахгүй юм.

Авч хэрэгжүүлэх гол арга хэмжээ:

1а. Чанарыг хянан шалгах, мониторингийн мэдээллийн сан байгуулж хөтлөх

1б. Нийлүүлэгчийн гэрээний загварт түлшний шинжилгээний тодорхой шаардлагуудыг тусгах

1в. Боловсруулсан түлшний стандартад буй хийдэл, дутагдлыг тогтоож, сайжруулах

2.3 Түгээлтийн тасалдал болон бүрэн бус нийлүүлэлт

Нийлүүлэгч бүр “Боловсруулсан түлшний нөөц бүрдүүлэхтэй холбогдуулан түлш нийлүүлэх, түүнийг урьдчилан худалдан авах” гэрээг НЗДТГ (НАЧА) болон ЦАС-тай байгуулдаг. Энэ гэрээ нь боловсруулсан түлшний хангалтын хувь хэмжээ, хангах хуваарийг албадан хэрэгжүүлэх гол эрхзүйн акт юм. Энэхүү гэрээний биелэлтийг нэгдсэн мэдээллийн санд доорхи хүснэгтийн загварын дагуу бүртгэж байх хэрэгтэй.

Нийслэлийн МХГ нь эдгээр түлшний чанарыг шалгаад НАЧА-д мэдээлдэг үүрэгтэй байх нь зөв юм². Харин хэдий хугацаанд яаж мэдээлж байхыг тодорхой болгох нь зүйтэй.

² “Агаарын чанарыг сайжруулах бүс дэх түүхий нүүрсийг хязгаарлах үндсэн бүсэд орших айл өрхийг боловсруулсан түлшээр хангах нөөц бүрдүүлэхтэй холбогдуулан урьдчилгаа санхүүжилт олгох тухай журам”-ын 6.1-д Нийслэлийн мэргэжлийн

Нийлүүлэгчийн гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулахаас өмнө тухайн нийлүүлэгчийн үйлдвэрлэлийн хүчин чадлыг бодитойгоор үнэлсэн байх шаардлагатай. Түрүүчийн гэрээнүүдэд үйлдвэрлэгчдийн хүчин чадлыг хэт өөдрөгөөр үнэлсэн байдаг. Иймд үйлдвэрлэгчдийн хүчин чадлыг үнэлэх асуудлыг ЦАС болон хотын захиргааны үндсэн үүрэг гэж үзэн хариуцлагатай хандах ёстой.

2.4 Иргэний хуультай зөрчилдсөн зохицуулалт

Иргэний хуулийн 232.6-д **“Хууль болон гэрээнд заасан хугацаа хэтрүүлсэн тал нь хоног тутам гүйцэтгээгүй үнийн дүнгийн 0.5 хувиас хэтрэхгүй хэмжээгээр төлөхөөр тогтоосон анзыг алданги гэнэ”** гэж заасан байдаг. Гэтэл дээрх гэрээнд алдангыг 10 хувиар тооцож оруулсан нь Иргэний хуулийн дээрх заалтад нийцэхгүй байсан юм.

Авч хэрэгжүүлэх гол арга хэмжээ:

2а Түлшний хэмжээг хянах мониторингийн мэдээллийн сан байгуулах
2б Гэрээнд ханган нийлүүлэгч талд тавигдах торгуулийг Иргэний хуульд нийцүүлэн шинэчлэх

2.5 Сав баглаа

Боловсруулсан түлшний сав, баглаа, боодлын шаардлагыг зохицуулсан эрх зүйн зохицуулалт хангалтгүй байгаа юм. Жишээ нь савлагааны материалын чанарын асуудал тодорхойгүй байна. “Боловсруулсан түлш нөөцлөх, дүүрэг, хороо, иргэдэд хүргэх журам”-н 2.9-д “түлшний жижиглэнгийн сав, баглаа боодлыг зориулалтын дагуу чанартай материалаар хийж, түлшний хэв загварыг харуулсан зураг болон бүтээгдэхүүний нэр, жин, үйлдвэрлэсэн он, сар, өдөр, үйлдвэрлэгчийн нэр, хаяг, хадгалалт, хэрэглэх зааврыг тодорхой бичиж, гарах зардлыг түлш үйлдвэрлэгч аж ахуйн нэгж, байгууллага өөрсдөө хариуцах бөгөөд энэ нь гурвалсан гэрээнд батлагдсан түлшний борлуулалтын үнэд орж тооцогдсон байна” гэжээ. Ийнхүү уг журамд тодорхойлсон хэдий ч сав, баглаа боодлын зөвшөөрөгдөх материал, битүүмжлэл ямар байх зэрэг стандарт байхгүй байгаагаас энэхүү заалтыг бодитой хэрэгжүүлж хариуцлага тооцоход хүндрэлтэй байгаа юм. Түүнчлэн “Боловсруулсан түлшний нөөц бүрдүүлэхтэй холбогдуулан түлш нийлүүлэх, түүнийг урьдчилан худалдан авах” гэрээний загвараас үзэхэд уг гэрээнд боловсруулсан түлшний сав, баглаа боодлын чанарын шаардлагыг тусгасан заалт байхгүй байна. Зөвхөн гэрээний 5.1.10 “сав, баглаа боодол дээр түлшний хэв загварыг харуулсан зураг бүтээгдэхүүний нэр, жин, үйлдвэрлэгчийн нэр, хаягийг тодорхой бичсэн байна.” гэж заасан байх бөгөөд энэхүү заалт нь дээрх журмын 2.9-д заасан бүхий л шаардлагыг тусгаагүйгээс гэрээний заалт болон журмын заалтын алийг нь нийлүүлэгч дагаж мөрдөх ёстой болох талаар ойлгомжгүй нөхцөл байдал бий болж байгаа юм.

Авч хэрэгжүүлэх гол арга хэмжээ

2в Гэрээнд ханган нийлүүлэгч талд тавигдах шаардлагуудыг холбогдох хууль тогтоомжуудад нийцүүлэн тусгах
2г Савлагааны стандартыг дахин нягтлан боловсруулж мөрдүүлэх

2.6 Боловсруулсан түлшний ханган нийлүүлэлттэй холбоотой маргааныг шийдвэрлэх

2.6.1 Маргаан шийдвэрлэх

Хэрвээ хууль тогтоомж, журмууд холбогдох гэрээнүүд нь тодорхой нарийвчилсан мөн бодитой тохиолдолд талуудын хоорондын маргаан зөрчлөөс сэргийлэх боломжтой. Маргааныг аль болох эвлэрүүлэх аргаар шийдвэрлэх нь үндсэн зарчим байх ёстой. Гэрээт

хяналтын газар, дүүрэг, хороон засаг дарга нар, дүүргийн агаарын чанарын хяналтын ажилтнууд болон ЦАС нь Цэвэр түлш хүлээж авах, хадгалах, худалдаалах ажлын хяналтыг гүйцэтгэнэ гэжээ.

нийлүүлэгчтэй ямар нэгэн маргаан гарвал төрийн байгууллагын хувьд НЗДТГ энэ маргааныг шийдвэрлэх үүрэгтэй.

Маргаан зөрчил нь голлон гэрээт талууд болох ЦАС, хувийн хэвшлийн компаниуд болон НАЧА-ны хооронд үүсэх магадлалтай. Өнөөгийн байдлаар ийм маргааныг хэрхэн шийдэх механизм хараахан алга байна. Тиймээс Иргэний хуулиар шийдэх арга зам үлдэж байгаа юм. Хэрэв зөрчлийг удаа дараа гаргасан тохиолдолд шаардлагыг нийлүүлэгч талд бичгээр тавих, бичгээр тавьсан шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд гэрээнээс татгалзах, учирсан хохирлоо нэхэмжлэх эрхтэй байдаг. Энэ нь гэрээг хоёр удаа зөрчихөд л гэрээг цуцлах талаар яригдаж эхлэх боломжтой гэсэн үг юм. Тиймээс холбогдох зохицуулалт нарийн байх шаардлагатай. Нөгөө талаар боловсруулсан түлшний үйлдвэрлэлийн салбар нь манай оронд харьцангуй шинэ тутам тул компаниуд технологи, түүхий эд зэргээс үүдэн хүндрэлтэй учрах эрсдэл нь эхэн үедээ өндөр байх нь зайлшгүй байх үзэгдэл юм. Тиймээс ЗГ-ын талууд гэрээг цуцлах тал дээр уян хатан байх хэрэгтэй.

Өнөөгийн нөхцөл байдал нь НЗДТГ нь маргааныг шийдэхэд төр засгийн зүгээс голлон оролцохоор байна. Иргэний хуулийн 225 дугаар зүйлийн 1-д “Талуудын аль нэг нь гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн бөгөөд үүрэг гүйцэтгэх нэмэлт хугацаа тогтоосон боловч үр дүн гараагүй бол нөгөө тал гэрээнээс татгалзах эрхтэй” гэж заасны дагуу нийлүүлэгч тал гэрээний үүргээ зөрчсөн, хугацаандаа үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч тал гэрээнээс татгалзах эрхтэй байна. Тиймээс компаниуд ч мөн адил гэрээг цуцлах эрхтэй ба ЗГ нь төлбөрийн хуваарийг зөрчсөн, удаасан тохиолдолд гэрээг цуцалж болно. Иргэний хуулиар нийлүүлэгч бүтээгдэхүүнээ нийлүүлж эхлэхээс өмнө авах арга хэмжээг тодорхой тусгасан байгаа ч бүтээгдэхүүнээ нийлүүлээд эхэлчихсэн хойнох зохицуулалт нь тодорхой биш байна.

2.6.2 Шүүхээр маргааныг шийдэх ба хохирлыг барагдуулах

Хэрвээ маргаантай асуудлыг шүүхээр шийдэх хэмжээнд хүрвэл Иргэний хуулиар голлон зохицуулагдана. Хохирлыг тооцохдоо Иргэний хуулийн 227.3 “Үүрэг гүйцэтгүүлэгчээс гарсан зардал, эд хөрөнгийн алдагдал буюу гэмтэл, үүрэг гүйцэтгэгч үүргээ гүйцэтгэсэн бол үүрэг гүйцэтгүүлэгчид зайлшгүй олох байсан орлогыг хохиролд тооцно” гэж заасны дагуу тооцож нэхэмжлэх эрхтэй юм. Тиймээс “Цэвэр агаарын сан” нь иргэний журмаар шүүхэд нэхэмжлэл гаргаж болох бөгөөд шүүх дараах тохиолдолд иргэний хэрэг үүсгэж хэргийг шийдвэрлэдэг.

- Эдийн ба эдийн бус баялагтай холбоотой эрх нь зөрчигдсөн тухай эрх зүйн харилцаанд оролцогч этгээдээс гаргасан нэхэмжлэл
- Бусдын эрх, эрх чөлөө, ашиг сонирхлыг хамгаалж шүүхэд мэдүүлэх эрх нь хуулиар олгогдсон этгээдээс гаргасан нэхэмжлэл
- Онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлүүлэхээр хуульд заасан асуудлаар сонирхогч этгээдээс гаргасан хүсэлт
- Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4.1, 4.2-т зааснаас бусад байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаа болон тэдгээрийн гаргасан захиргааны актын талаар гаргасан гомдол
- Хуульд заасан бусад үндэслэл³

Дээрх нэхэмжлэлийг шүүх хүлээн авч иргэний хэрэг үүсгэнэ.

Хуулиар өөр хугацаа тогтоогоогүй бол хэрэг үүсгэсэн өдрөөс хойш 60 хоног, давж заалдах болон хяналтын шатны шүүхээс хэргийг дахин хэлэлцүүлэхээр ирүүлсэн бол шүүгч хэргийг хүлээж авснаас хойш 30 хоногийн дотор тус тус шийдвэрлэнэ. Энэхүү хугацааг тухайн

³ Иргэний хуулийн 12 дугаар зүйлийн 12.1

шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс нэг удаа 30 хүртэл хоногоор сунгаж болно. Шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсны дараа шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулдаг. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь зохицуулагддаг⁴.

Маргаан шийдвэрлэх энэхүү процедурыг өнөөгийн хууль зүйн хүрээнд товч тайлбарлалаа. Гэхдээ НАЧА болон ЦАС нь өөрийн гэсэн нарийвчилсан гарын авлага боловсруулж гэрээлэгч талууддаа анхнаас нь нарийн ойлгуулах нь шүүх хүртэл асуудал даамжрахаас өмнө шийдэх гол арга зам билээ.

Авч хэрэгжүүлэх гол арга хэмжээ

2д: Талуудын хооронд үүсч болох маргаан, зөрчлийг шийдвэрлэх аргачлалыг ЦАС болон НЗДТГ-ын ажилтнуудад зориулан боловсруулах

⁴ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль 2002 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр

3 Агуулахтай холбогдох албадлагын арга ХЭМЖЭЭ

3.1 Эрх зүйн орчин

Боловсруулсан түлш нийлүүлэх ажиллагаанд гарч болох болзошгүй зөрчлүүдийг багцлан томъёолбол:

1. Агуулахын чанарын шаардлага,
2. Хадгалагдаж буй түлшний харуул хамгаалалт, аюулгүй байдал

Боловсруулсан түлшний хөтөлбөрийн хүрээнд түлшийг хадгалах ажиллагааг доорхи хоёр гол журам зохицуулдаг.

- 1) Боловсруулсан түлшийг хадгалах харилцааг мөн “Боловсруулсан түлш нөөцлөх, дүүрэг, хороо, иргэдэд хүргэх журам” болон талуудын хооронд байгуулагдаж байгаа агуулах түрээслэх гэрээгээр зохицуулж байна.
- 2) Мөн “Агаарын чанарыг сайжруулах бүс дэх түүхий нүүрсийг хязгаарлах үндсэн бүсэд орших айл өрхийг боловсруулсан түлшээр хангах нөөц бүрдүүлэхтэй холбогдуулан урьдчилгаа санхүүжилт олгох тухай журам” батлагдсан байна.

3.2 Албадлагыг арга хэмжээг хэрэгжүүлэх хууль зүйн өнөөгийн боломж

3.2.1 Агуулахад тавигдах шаардлага

“Боловсруулсан түлш нөөцлөх, дүүрэг, хороо, иргэдэд хүргэх журам”-д “стандартын шаардлага хангасан (дэд бүтэц сайтай, төмөр зам болон авто замтай, байнгын харуул хамгаалалттай, цас борооны ус нэвтрэхгүй битүүмжлэл сайтай)” агуулахад түлшийг хадгалахаар зохицуулжээ. “Агаарын чанарыг сайжруулах бүс дэх түүхий нүүрсийг хязгаарлах үндсэн бүсэд орших айл өрхийг боловсруулсан түлшээр хангах нөөц бүрдүүлэхтэй холбогдуулан урьдчилгаа санхүүжилт олгох тухай журам”-н 2.6-д “Технологийн шаардлага хангасан (дэд бүтэц сайтай, байнгын харуул хамгаалалттай, цас борооны ус нэвтрэхгүй) агуулах бүхий аж ахуйн нэгжид түлшийг гэрээгээр хадгалуулж болох ба зардлыг Нийслэлийн Засаг Даргын Тамгын газар хариуцна” гэж заажээ. Гэхдээ тухайн агуулахыг шаардлага хангах эсэхийг хэн тодорхойлохыг заагаагүй байна. Энэхүү асуудлыг тодорхойлоогүйгээс ямар ч этгээд агуулахыг шаардлага хангасан гэж үзэх боломжтой байгаа юм. Үүнийг тодорхой болгосноор чанарын шаардлага хангаагүй агуулахад түлш хадгалсан тохиолдолд хэн хариуцлага хүлээх нь тодорхой болох юм. Тиймээс түлшийг хадгалах агуулахын чанарын шаардлагыг нарийн тусгасан журам хэрэгтэй байна.

3.2.2 Хадгалагдаж буй түлшний харуул хамгаалалт, аюулгүй байдал

Түлшний хадгалалтын үеийн харуул хамгаалалт, аюулгүй байдал нь маш чухал тул энэ талаар дэлгэрэнгүй албадлагын арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлэх нь нэн чухал. Харин “Агуулах түрээслэх гэрээ”-ний загвараас үзэхэд агуулахаас түлш алдагдсан тохиолдолд хэн хариуцлага хүлээх, түрээслүүлэгч тал харуул, хамгаалалтыг бүрэн хариуцах тухай заалт байхгүй байна. Мөн боловсруулсан түлшийг хадгалахдаа түрээслүүлэгчийн харуул нь ямар горим баримтлах, түлшийг гаргах, зөөвөрлөх эрх бүхий этгээдийг агуулахын харуул хэрхэн мэдэх, галын аюулгүй байдлыг түлш хадгалах, зөөвөрлөх явцад хэрхэн баримтлах зэрэг харилцааг зохицуулсан дүрэм, журам, заавар байхгүй, харуул хамгаалалт болон хадгалалтын буруу үйл ажиллагаанаас учирсан хохирлыг хэн хэрхэн барагдуулах харилцааг зохицуулсан зохицуулалт байхгүй байгаа юм.

Энэхүү харилцаа нь Иргэний хуулийн 422 дугаар зүйлд заагдсан “Хадгалалтын гэрээнд” хамаарах юм. Тиймээс түлшийг хадгалах агуулахын харуул хамгаалалт, аюулгүй байдал шаардлагыг нарийн тусгасан журам хэрэгтэй байна. Түүнээс гадна энэхүү агуулахтай холбогдох бүхий л асуудлыг МХЕГ болон дүүргийн салбарууд хянах бүрэн боломжтой ба НАЧА болон ЦАС нь өөрийн хяналтыг МХЕГ-тай хамтран явуулах нь зүйтэй. Онцгой байдлын албад мөн адил түймэр, үер зэрэг эрсдэлүүдийг хянан дүгнэлт гаргаж байнгын хяналт явуулах хэрэгтэй.

3.2.3 Маргаан шийдвэрлэх

Агуулахтай холбогдох маргаан шийдвэрлэх горим нь энэ тайлангийн 2.1.5-р хэсэгт өгүүлсэн цэвэр түлш үйлдвэрлэгчдийнхтэй адил болно.

Авч хэрэгжүүлэх гол арга хэмжээ

3 Агуулахуудад тавигдах шаардлагууд, хяналт шалгалт явуулах процедур, цэвэр түлшийг хэрхэн хадгалах зэргийг багтаасан журам боловсруулах хэрэгтэй.

4 Тээвэрлэлттэй холбоотой албадлагын арга хэмжээ

4.1 Боловсруулсан түлш тээвэрлэх ажиллагааг зохицуулж буй эрх зүйн актууд

Боловсруулсан түлшийг тээвэрлэх асуудлыг зохицуулсан эрх зүйн акт байхгүй байгаа бөгөөд зөвхөн талуудын хооронд байгуулагдаж буй тээвэрлэлтийн гэрээгээр энэхүү боловсруулсан түлш тээвэрлэх харилцаа зохицуулагдаж байгаа гэж үзэж болохоор байна. Тээвэрлэлтийн гэрээний хувийг гэрээний талуудын нууцлалтай холбогдуулан төслийн багт өгөөгүй тул гэрээнд дүн шинжилгээ хийх боломжгүй байсан болно.

Гэхдээ энэ харилцааг Иргэний хуулийн холбогдох зүйл “Тээвэрлэлтийн гэрээ”-ний зохицуулалтаар зохицуулахаар байна.⁵

Боловсруулсан түлш тээвэрлэх ажиллагааны үед хэрэгжилт нь зөрчигдөж болзошгүй хоёр гол асуудал:

1. Тээвэр хийх автомашинд тавигдах шаардлага
2. Тээвэрлэлтийн явцад бараа гэмтэх, гээгдэх, чанараа алдах

4.2 Хэрэгжилтийг хангах эрх зүйн боломж

4.2.1 Тээвэр хийх автомашинд тавигдах шаардлага

Боловсруулсан түлшийг тээвэрлэх тээврийн хэрэгсэлд тавигдах шаардлагыг тодорхойлсон эрх зүйн акт байхгүй, тээврийн компанитай хийсэн гэрээнд ч тусгаагүй байна. Иймээс тээврийн хэрэгсэлд тавигдах тусгай шаардлагыг тодорхойлж мөрдүүлэх нь зүйтэй.

4.2.2 Тээвэрлэлтийн явцад бараа гэмтэх, гээгдэх, чанараа алдах

Боловсруулсан түлшний тээвэрлэлтийг тусгайлан зохицуулсан эрх зүйн акт байхгүй учир энэ асуудлыг Иргэний хуулиар зохицуулах боломжтой. Иргэний хуулийн 393 дугаар зүйлд тээвэрлэгчийн хариуцлагыг тодорхойлсон байдаг: *“Тээвэрлэгч ачааг хүлээн авснаас хойш хүлээлгэн өгөх хүртэлх хугацаанд ачаа алдагдсан, дутсан, гэмтсэн, түүнчлэн тээвэрлэлтийн хугацаа хоцроосны хариуцлагыг бүхэлд нь буюу хэсэгчлэн хариуцна. Гэхдээ эрх бүхий этгээдийн буруугаас, эсхүл түүний зааварчилгыг биелүүлснээс ачаа алдагдсан, дутсан, гэмтсэн буюу тээвэрлэлтийн хугацаа хэтэрсэн, эсхүл дээрх нөхцөл байдал, түүний үр дагаврыг урьдчилан арилгах боломж тээвэрлэгчид байгаагүй бол тээвэрлэгч хариуцлагаас чөлөөлөгдөнө”*.

Мөн дараах нөхцөл байдлын улмаас ачаа алдагдсан, дутсан буюу гэмтсэн бол тээвэрлэгч хариуцлагаас чөлөөлөгдөхөөр заажээ⁶:

- талууд шууд тохиролцон, дагалдах бичигт тэмдэглэснээр задгай тээврийн хэрэгсэл ашигласан

⁵ Монгол улсын иргэний хуулийн 35-р зүйл

⁶ Иргэний хуулийн 393 дугаар зүйлийн 393.6. “Энэ хуулийн 393.4-т заасан нэг буюу хэд хэдэн нөхцлийн улмаас ачаа алдагдсан, дутсан буюу гэмтсэнд гэм буруугүй болохоо тээвэрлэгч нотолж чадвал хариуцлагаас чөлөөлөгдөнө.” 393.7. “Энэ хуулийн 393.4.1-д заасан тохиолдолд давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас ачаа алдагдсан, дутсан, гэмтсэн бол энэ хуулийн 393.6 хамаарахгүй.” 393.8. “Энэ хуулийн 384.3-т заасан журам ачаа тээвэрлэгчид нэгэн адил хамаарна.”

- ачаа сав, баглаа, боодолгүй буюу түүний чанар муу байсан
- ачаа илгээгч, хүлээн авагч, эсхүл тэдгээрийг төлөөлөх гуравдагч этгээд ачаанд үзлэг хийж ачсан буюу буулгасан
- тодорхой төрлийн ачааны онцлогоос хамаарч эвдрэх, зэврэх, хатах, элэгдэх, хэвийн алдагдал гарах, асгарах болон мэрэгч амьтдын нөлөөлөл зэргээр хэсэгчлэн буюу бүрэн гэмтэх аюул байсан
- тээвэрлэх ачааны дугаар буюу тэмдэглэл шаардлага хангаагүй байсан

Иймээс тээвэрлэгчтэй гэрээ байгуулахдаа дээрх асуудлуудыг зайлшгүй тусгаж өгөх шаардлагатай.

4.3 Хэрэгжилтийг шалгах

Тээвэрлэсэн цэвэр түлшний хэмжээ, тээврийн цаг зэргийг нарийн тусгасан маягтыг тээвэрлэгч компани бөглөдөг. Энэ мэдээллийг хавтаслан хадгалж, долоо хоног тутамд компьютерт хүснэгтэн мэдээлэл болгон оруулж байвал зохино. Мөн гэрээний биелэлт хангагдаагүй тохиолдлыг ч уг файлд тэмдэглэж байх хэрэгтэй.

4.4 Маргаан шийдвэрлэх арга хэмжээг хэрэгжүүлэх

4.4.1 Харилцан тохиролцож маргаан шийдвэрлэх

Иргэний хуулинд тээвэрлэлттэй холбогдож гарах маргааны талаар дараах заалтуудыг тусгажээ:

- Ачаа хүлээн авагч ачааг хүлээн авахдаа тээвэрлэгчтэй хамт түүнийг шалгаагүй, эсхүл алдагдсан, дутсан ачааны болон учирсан хохирлын талаар ямар нэгэн шаардлага тээвэрлэгчид гаргаагүй бол эсрэгээр нотлогдох хүртэл ачаа хүлээн авагч ачааг дагалдах бичигт заасан байдлаар хүлээн авсанд тооцно.
- Ачаа хүлээн авагч ачааны илэрхий гэмтэл, дутагдлын талаархи шаардлагыг ачаа хүлээн авсан өдөр, харин далд дутагдалтай холбоотой шаардлагыг ачааг хүлээн авсан өдрөөс хойш 7 хоногийн дотор бичгээр тээвэрлэгчид гаргана.
- Ачаа хүлээн авагч, тээвэрлэгч талууд ачааны байдлыг хамтран шалгасан боловч нуугдмал дутагдал, гэмтлийг тухайн үед илрүүлж чадаагүй бол ажлын 7 хоногийн дотор шалгасан үр дүнгийн талаар эсрэг нотолгоо гаргаж болно.
- Ачаа хүлээн авагч хугацаа хэтэрсэнтэй холбоотой шаардлага ачаа хүлээн авсан өдрөөс хойш 21 хоногийн дотор тээвэрлэгчид бичгээр гаргасан тохиолдолд хугацаа хэтэрснээс үүссэн хохирлыг нөхөн төлүүлэх эрхтэй. Энэ зүйлд заасан хугацааг тоолохдоо ачаа илгээсэн, шалгасан буюу хүлээлгэж өгсөн өдрийг оролцуулан тооцохгүй. Тээвэрлэгч, ачаа хүлээн авагч талууд шаардлагатай шалгалт хийх, зайлшгүй хэрэгтэй гэж үзсэн хүчин зүйлүүдийг тогтооход бие биедээ харилцан туслах үүрэгтэй.

Тээвэрлэлтийн гэрээнээс үүсэх шаардах эрхийн хөөн хэлэлцэх хугацаа нэг жил, санаатай буюу илтэд болгоомжгүй үйлдлийн улмаас хохирол учирсан бол хөөн хэлэлцэх хугацаа гурван жил байдаг⁷. Хөөн хэлэлцэх хугацааг ачаа алдагдсан, гэмтсэн өдрөөс буюу энэ тухай мэдсэн, мэдэх ёстой байсан өдрөөс, эсхүл хүлээлгэн өгөх хугацааг хэтрүүлсэн бол ачааг хүлээн авах байсан өдрөөс, ачааны зарим хэсэг алдагдсан тохиолдолд тээвэрлэлтийн гэрээгээр тохирсон ачааг хүлээлгэн өгөх хугацаа дууссанаас хойш 30 дахь өдрөөс, ийм хугацаа товлоогүй бол тээвэрлэгч ачаа хүлээн авснаас хойш 60 дахь өдрөөс, бусад тохиолдолд гомдлын шаардлагын хариуг авсан буюу гомдлын шаардлага гаргах хугацаа дууссан өдрөөс эхлэн тоолно.

⁷ Иргэний хуулийн 395 дугаар зүйлийн 1 дэх заалт

4.4.2 Шүүхээр маргаан шийдвэрлэх

Шүүхээр тээврийн компаниудын маргаан шийдвэрлэх горим нь энэ тайлангийн 2.1.5-р хэсэгт өгүүлсэн цэвэр түлш үйлдвэрлэгчдийнхтэй адил болно.

Авч хэрэгжүүлэх гол арга хэмжээ

4 Цэвэр түлш тээвэрлэгчдийн ажиллагааны горим, удирдамжийг боловсруулах

5 Жижиглэн борлуулахтай холбоотой албадан хэрэгжүүлэх арга хэмжээ

5.1 Боловсруулсан түлш борлуулах ажиллагааг зохицуулж буй эрх зүйн актууд

Боловсруулсан түлш жижиглэн борлуулах үйл ажиллагааг ерөнхийд нь “Боловсруулсан түлш нөөцлөх, дүүрэг, хороо, иргэдэд хүргэх журам”, “Агаарын чанарыг сайжруулах бүс дэх түүхий нүүрсийг хязгаарлах үндсэн бүсэд орших айл өрхийг боловсруулсан түлшээр хангах нөөц бүрдүүлэхтэй холбогдуулан урьдчилгаа санхүүжилт олгох тухай журам” зэргээр зохицуулж байна.

5.2 Болзошгүй зөрчил

Түлш борлуулах үйл ажиллагааны явцад гарч болзошгүй зөрчил:

1. Жижиглэн борлуулагчдад тавигдах шаардлага зөрчигдөх
2. Борлуулагчийн учруулсан хохирлыг төлүүлэх
3. Ваучер болон санхүүжилттэй холбоотой асуудлууд

Түүхий нүүрс, хог хаягдал түлэх, шатаахыг хориглосон заалтын хэрэгжилтийн асуудлыг 6-р бүлэгт орууллаа.

5.3 Хэрэгжилтийг хангах эрх зүйн боломж

5.3.1 Жижиглэн борлуулагчдад тавигдах шаардлага

“Боловсруулсан түлш нөөцлөх, дүүрэг, хороо, иргэдэд хүргэх журам”-нд боловсруулсан түлш жижиглэн борлуулах цэгт тавигдах шаардлагыг заажээ. Үүнд:

- Тухайн хорооны байнгын оршин суугч байх
- Борлуулах цэг нь 2-3 хоногийн нөөц хадгалах шаардлага хангасан байх
- Борлуулах цэгийн байршил нь агаарын бохирдлыг бууруулах салбар хорооны борлуулалтын цэгийн төлөвлөлтөд нийцсэн байх
- Хороон засаг даргын тодорхойлолтоор борлуулагчийг баталгаажуулсан байх,
- Борлуулагч гэрээ байгуулах, үүсэн гарах эрсдэлийг хүлээх чадвартай байх

“Жижиглэн борлуулагчийн агуулах стандартын шаардлага хангасан байна” гэж “Боловсруулсан түлш нөөцлөх, жижиглэн худалдах гэрээ” “Боловсруулсан түлш нөөцлөх, дүүрэг, хороо, иргэдэд хүргэх журам”-д заасан хэдий ч яг ямар стандартад нийцсэн байх нь тодорхойгүй байгаа юм. Хэдийгээр нөхцөл байдлын хувьд хэт өндөр үзүүлэлт бүхий агуулахын стандарт тавих боломжгүй байгаа хэдий ч аюулгүй байдал болон түлшний чанар алдагдуулахгүй байх хэмжээний наад захын ерөнхий шалгуурыг тодорхойлох зайлшгүй шаардлагатай билээ. Мөн жижиглэн борлуулагч нь боловсруулсан түлш хадгалах талаар анхан шатны мэдлэгтэй, худалдан авагчдад түлшийг хэрхэн ашиглах талаар тодорхой мэдээлэл өгөх чадвартай байх шаардлагатай бөгөөд борлуулагчдыг ийм гарын авлага, зааварчилгаагаар хангах нь зүйтэй. Энэ асуудлыг үндэсний стандартад тусгах нь зүйтэй.

5.3.2 Борлуулагчийн учруулсан хохирлыг төлүүлэх

“Боловсруулсан түлш нөөцлөх, жижиглэн худалдах гэрээ”-ний 3.5-д “борлуулагч нь түлшийг хүлээн авснаас хойш өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас учруулсан

хохирлыг бүрэн хариуцах үүрэгтэй” гэсэн заалт байх хэдий ч хэрэгжихэд хүндрэлтэй юм.
Учир нь:

1. Борлуулагч нарын төлбөрийн чадвар харьцангуй бага
2. Боловсруулсан түлшийг хадгалах горим, заавар байхгүй юм.

Иймээс жижиглэн борлуулах цэгийг даатгалд хамруулах, мөн боловсруулсан түлшийг хадгалах зааварчилгаа боловсруулж борлуулагч нарт танилцуулан гарын үсэг зуруулж баталгаажуулан авах шаардлагатай.

Мөн жижиглэн борлуулах цэгийн борлуулагчийн хариуцлагыг өндөржүүлэхийн тулд гэрээнд жижиглэн борлуулагч цагийн хуваарийн дагуу ажиллаагүй, худалдан авагчаас жижиглэн борлуулагчийн талаар гомдол ирсэн нь үндэслэлтэй бол урамшууллаас тодорхой хэмжээгээр суутгах хариуцлага тооцох заалт оруулах шаардлагатай гэж үзэж байна.

5.4 Ваучер болон санхүүтэй холбоотой асуудал

Борлуулагчид цэвэр түлшний ваучераар түлш борлуулж, орлогыг тушаах үүрэгтэй. Борлуулагчид түлш борлуулсан түлшнийхээ хэмжээгээр урамшуулал авдаг. Борлуулагч нь түлш нөөцлөхөд зориулж багагүй хэмжээний хөрөнгө оруулах шаардлагатай байдгийг харгалзан үзэж цаашид урамшууллын мөнгөний тодорхой хэсгийг урьдчилан авахаар гэрээнд тусгах нь зүйтэй. Орлогыг нь боллоцот доод хэмжээнээс доош оруулахгүй байхыг анхаарах нь чухал. Ваучер, санхүүтэй холбоотой зөрчлөөс сэргийлэхийн тулд бүх борлуулагчдыг эхний жил аудитад оруулах нь зүйтэй. Дараа дараагийн жилийн аудит санамсаргүй түүврээр хийгдэж болох юм.

5.5 Маргаан шийдвэрлэх арга хэмжээг хэрэгжүүлэх

5.5.1 Маргаан шийдвэрлэх

Жижиглэн борлуулагчийн хариуцлагагүй үйл ажиллагааны улмаас хохирол учирсан тохиолдолд төлбөрийг хэрхэн ямар арга замаар барагдуулах талаар тодорхой зохицуулалт бүхий журам шаардлагатай байгаа юм. Жижиглэн борлуулагч нар төлбөрийн чадвар муутайгаас учирсан хохирлыг түүнд олгох хөлс, урамшууллаас суутгах, мөн жижиглэн борлуулагч нарыг даатгалд хамруулах арга хэмжээг шийдвэрлэх шаардлагатай гэж үзэж байна. Жижиглэн борлуулагч нь байгуулсан гэрээний үүргээ биелүүлээгүй, эсхүл зөрчсөний улмаас учруулсан хохирлыг сайн дураараа төлөөгүй, эсхүл түүний төлөх төлбөр түүнд олгох хөлс, урамшууллын хэмжээнээс суутгаж төлүүлэх боломжгүй их хэмжээний хохирол байгаа тохиолдолд шүүхээр шийдвэрлүүлнэ.

Авч хэрэгжүүлэх гол арга хэмжээ

5 Жижиглэн борлуулагчдын түлш хадгалалтанд тавигдах шаардлага, борлуулагчдын учруулсан хохирлыг төлүүлэх, маргаан шийдвэрлэх тусгай процедурыг боловсруулах

6 Түүхий нүүрс, хог хаягдал түлэхийг хориглох тухай

6.1 Эрх зүйн орчин

Боловсруулсан түлш хэрэглэх үндсэн бүсэд түүхий нүүрс болон хог хаягдал шатаахыг Агаарын тухай хуулиар хоригложээ (Хүснэгт 3). Боловсруулсан түлшний нийлүүлэлт хангалтгүй байгаагаас энэ одоо болтол хэрэгжүүлж чадахгүй байгаа билээ. Ийнхүү ард иргэд түүхий нүүрс, хог хаягдлаа түлсээр байна.

Хүснэгт 1: Агаарын чанарыг сайжруулах бүсэд түүхий нүүрс, хог хаягдал шатаахыг хориглосон Агаарын тухай хуулийн заалт

16 дугаар зүйл. Агаарын чанарыг сайжруулах бүсэд хориглох зүйл

16.1. Агаарын чанарыг сайжруулах бүсэд дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

16.1.1. зориулалтын бус газарт хог хаягдал хаях, ил задгай шатаах

16.1.5. түүхий нүүрс болон агаар бохирдуулах бусад хаягдал зүйлс шатаах

6.2 Хөтөлбөрийн дизайн

Агаар бохирдуулагч материал шатаах, хаяхыг хориглосон хоригийн хэрэгжилтийг хангах эхний алхам нь хөтөлбөрийн нягт нямбай төлөвлөлт юм. Хоригт ахуйн болон аюултай хог хаягдлыг зааглаж өгөх шаардлагатай. Хаягдал цаас, мод зэрэг хоргүй хог хаягдлыг нүүрстэй адил үзэж болох бөгөөд хуванцар, резин, битумтай материал, тос зэрэг хортой хаягдлыг ямар ч тохиолдолд шатаахыг бүр мөсөн хориглох хэрэгтэй. Дугуй шатаахад ялгардаг бодисын хор хөнөөлийг маш нарийн судалж баталсан байна⁸. Гэр хороололд өрхийн түлшний хэрэгцээнд зориулан худалддаг гэсэн мэдээлэл байна. Үүнийг зогсоох шаардлагатай. Энэ асуудлыг зохицуулах тусгайлсан дүрэм журам, торгож шийтгэдэг системтэй болох шаардлагатай.

Засгийн газраас боловсруулсан түлш үйлдвэрлэгчдийн хүчин чадлыг бодитойгоор үнэлж байж түүнтэй уялдуулан энэ бүсийн хэмжээг тогтоох ёстой. Хүйтний улирлын эхнээс бүсийн оршин суугчдад боловсруулсан түлш хүрэлцээтэй байвал түүхий нүүрс, хог хаягдал шатаах хоригийн хэрэгжилтийг хангах боломжтой болно. Манай төслөөс саяхан явуулсан судалгаанд оролцсон маш олон иргэд түлшиндээ түүхий нүүрс хэрэглэсээр байгаа, зарим нь бүр зөвхөн хог хаягдлаар аргацааж байна гэсэн байна.

⁸ АНУ-ын Байгаль орчныг хамгаалах агентлаг 1997 оны тайландаа дугуйг ил задгай шатаахад тоосонцрууд, нүүрстөрөгчийн дан исэл (CO), хүхрийн ислүүд (SOx), азотын ислүүд (NOx), дэгдэмхий органик нэгдлүүд (VOCs) зэрэг агаарын гол бохирдуулагч бодисууд ялгардаг гэжээ. Түүнчлэн олон цөмт үнэрт нүүрс устөрөгч (PAHs), диоксин, фуран, хлорт устөрөгч, бензен, полихлорт бифенил (PCBs) зэрэг агаар бохирдуулагч бусад хорт бодисууд (HAPs), хүнцэл, кадмий, никель, цайр, мөнгөн ус, хром, ванади зэрэг метал илэрчээ. Дугуйны задгай шаталтаас үүссэн аль ч төрлийн бохирдуулагчид болон хорт бодисууд нь гал сөнөөгч болон ойролцоох оршин суугчдын эрүүл мэндэд аюултай нөлөө үзүүлж, богино хугацааны хурц, урт хугацааны архаг өвчин үүсгэдэг. Хорт бодист өртсөн хугацаа, өртөлтийн зэргээс хамаараад арьс, нүд, салст бүрхэвч улайх, амьсгалын зам гэмтэх, төв мэдрэлийн систем сааталд орох, хорт хавдар тусах зэрэг үр дагавартай. Дугуйны томоохон галын дэргэд ажиллаж буй гал сөнөөгчид болон бусад хүмүүс амьсгалын зам, арьсаа хамгаалсан хувцас, хэрэгсэл хэрэглэх шаардлагатай. Хамгаалалтгүйгээр утаанд нь өртөхөөс зайлсхийх хэрэгтэй.

6.3 Мэдээлэл сурталчилгаа

Хоёрдугаар алхам бол хоригийг ард иргэдэд таниулж мэдүүлэх явдал юм. Түүхий нүүрс, хог хаягдал түлшинд хэрэглэхийг багасгахын тулд засгийн газар гэр хорооллын иргэдэд зориулан өргөн хүрээтэй мэдээлэл сурталчилгааны кампанит ажил зохион байгуулах шаардлагатай. Кампанит ажлаар дугуй, хог хаягдал, түүхий нүүрс шатаахад эрүүл мэндэд ямар хор хөнөөлтэйг үзүүлэхийг зорино. Зарим хүмүүс нүүрсээ эрт нөөцөлдгийг бодолцон кампанит ажлыг хүйтний улирлаас өмнө эхлүүлбэл зохино. Засгийн газар хязгаарлалтын бүсэд тавьсан түүхий нүүрсний хоригийг онцлон сурталчилж, цэвэр түлшийг хэрхэн хүрэлцээтэй болгохоо тайлбарлан таниулна. Түүнчлэн хог хаягдал шатаахын эсрэг хууль сахиулах арга хэмжээг мэдээлж, ямар төрлийн хог хаягдал шатаах нь хориотой гэдгийг нарийвчлан тайлбарлаж ард иргэдэд ойлгуулна.

6.4 Нийцлийн мониторинг

Гурав дахь алхам бол хоригийг дагаж мөрдөж буй эсэхийг хянах мониторингийн систем бий болгох явдал. Хороодод өдөр тутмын мониторингийг хэсгийн ахлагч нар гүйцэтгэж байгаа. Хэсгийн ахлагч нар доорх хүснэгтийг бөглөн ЦАС болон хотын захиргаанд хүргүүлнэ. Улаанбаатар хотын захиргаа захирамж гарган мониторингийн системийг албажуулах хэрэгтэй.

Бүх хороодод хог хаягдал шатаахын аюул, хор холбогдлыг сэрэмжлүүлсэн хийгээд энэ нь хуулиар хориотой гэдгийг ухуулсан таниулга хуудас байрлуулах хэрэгтэй. Өвлийн улирал эхлэхээс өмнө хэсгийн ахлагчдыг мониторингийн ажилд нь сургаж бэлтгэнэ. Хүйтний улирал эхлэхэд тэд хариуцсан нутаг дэвсгэр дээрээ хяналтаа хийж, мэдээллээ НАЧА-д хүргүүлж байна. Энэ нь хэсгийн ахлагчийн үндсэн үүргээс гадуурх нэмэлт ажил тул тодорхой хэмжээний урамшуулал нэмж олгож болох талтай.

Хүснэгт 2 Хэсгийн ахлагчид зориулсан мониторингийн хуудас

Шалгалт хийсэн хүний нэр	Огноо:	Хамрагдсан хороо/хэсэг:
Мониторингийн мэдээлэл		Тайлбар
Хамрагдсан өрхийн тоо		
Түүхий нүүрс хэрэглэж буй өрхийн тоо		
Хог хаягдал, дугуй түлж буй өрхийн тоо		
Цэвэр түлш нь хүрэлцэхгүй байгаа өрхийн тоо		
Ваучер/төлбөртэй холбоотой илэрсэн зөрчлийн тоо		
Түлшний чанарын талаар гомдолтой өрхийн тоо		
Бусад ажиглагдсан зүйлс		

Ирүүлсэн мониторингийн мэдээллийг НАЧА нэгтгэн дүгнэж зөрчил ихээр гарч байгаа газарт нэмэлт шалгалт шаардлагатай гэж үзэж болно. Ийм шалгалтыг хотын мэргэжлийн хяналтын газартай хамтарсан хэлбэрээр явуулж болох юм.

6.5 Хяналт шалгалт, торгууль шийтгэл

Түлшний нийлүүлэлт хангалттай болчихвол иргэдэд хориг болон хоригийг мөрдүүлэх хяналтын систем бий болсныг таниулах шаардлагатай. Засгийн газраас торгууль, шийтгэлийн системийг бий болгоно. Энэ нь хэрэглээ, борлуулалтын аль алинд чиглэгдсэн байна. Мониторингийн системээрээ дамжуулан засгийн газар хаана түүхий нүүрсний хэрэглээ өндөр байгаа, хаана аюултай хог шатаах зөрчил их гардаг талаар мэдэж байх боломжтой болно. Албадан хэрэгжүүлэх ажлыг энэ бүс рүү чиглүүлэх юм. Нийслэлийн МХГ санамсаргүй түүврээр шалгалт явуулахаас гадна зөрчил ихээр гардаг бүсүүдэд хяналт хийж байх юм. Зөрчлийг багасгахын тулд хүйтний улирлын эхэнд засгийн газар шалгалт хийнэ гэдгээ зарлачих хэрэгтэй. Шалгалт хийх хүний болон санхүүгийн нөөц боломжоос хамааран шалгалтыг хэдэн удаа явуулахыг шийднэ.

Дугуй, аюултай хог хаягдал, түүхий нүүрс түлсэн өрхүүдийг торгож шийтгэх талаар дүрэм журам боловсруулж мөрдүүлэх хэрэгтэй. Энд түлш хүрэлцээтэй байгаа эсэхийг харгалзаж үзэх шаардлагатай. Боловсруулсан түлшний нийлүүлэлт хангалтгүй байсан бол торгуулиас чөлөөлөхөөр тусгана. Цэвэр түлш дээд тал нь ямар хугацаагаар хомсдоход айл өрхүүд түүхий нүүрс түлэхгүй байх ёстойг журманд тодорхой тусгах ёстой. Төслийн “Түлш орлуулах үйл ажиллагааны хүрээ” баримт бичигт албадан хэрэгжүүлэх арга хэмжээг хэрэглэгчдэд аль болох чиглүүлэхгүй байхыг зөвлөсөн байна. Харин түүхий нүүрсний борлуулалт, тээвэрлэлт рүү хяналтыг хандуулж болох боловч одоогоор цэвэр түлшний бүсийн хэмжээг харахад энэ нь боломжгүй бөгөөд хэдэн жилийн дараа боломжтой болж магадгүй юм. Ирланд улсад цэвэр түлшний хэрэглээг нэвтрүүлсэн туршлага зарим талаараа Монголынхтой төстэй байдаг. Тухайлбал тэд эхэндээ албадан хэрэгжүүлэх арга хэмжээг борлуулалтад л чиглүүлж байсан байна. Саяхнаас үүнийг хэрэглээ рүү чиглүүлж түүхий нүүрсний хэрэглэхийг хоригложээ. Иймэрхүү албадлагын механизм нь боломжийн үнэтэй цэвэр түлш хүрэлцээтэй болж байж л хэрэгждэг байна.

Шатлалтай торгуулийн систем хэрэглэж болох юм. Анх удаа гаргасан зөрчилд сануулга өгч, хоёр болон түүнээс цааш давтан зөрчил гаргавал нэмэгдүүлсэн торгууль онооно. Бид дараах торгуулийн системийг санал болгож байна. Боловсруулсан түлшний хүрэлцээтэй болчихвол мөрдөгдөх торгуулийн хэмжээг тогтоох хэрэгтэй. Торгуулийн орлого юунд ашиглагдахыг Засгийн газар тогтооно. Одоогийн байдлаар хэсгийн ахлагчид торгуулийг цуглуулах үүрэгтэй байгааг мэргэжлийн хяналтын байцаагч руу шилжүүлэх нь зүйтэй. Хэсгийн ахлагчид нь тухайн бүсийн иргэдийн төлөөлөл бөгөөд торгох, шийтгэх ажил хийхгүй байх нь цэвэр түлшийг сурталчилах үүргээ биелүүлэхэд амар болно.

	Түүхий нүүрс шатаасан тохиолдол	Аюултай хог хаягдал шатаасан тохиолдол	Дугуй шатаасан тохиолдол
Эхний зөрчил	Сануулга	Сануулга	Сануулга
2013-2014 оны өвөл давтаж зөрчвөл	50,000 төгрөг	100,000 төгрөг	100,000 төгрөг
2014-2015 оны өвөл зөрчвөл	80,000 төгрөг	200,000 төгрөг	200,000 төгрөг
2015-2016 оны өвөл зөрчвөл	100,000 төгрөг	300,000 төгрөг	300,000 төгрөг

Худалдаанд хийх хяналт шалгалт нь түүхий нүүрс, хортой хог хаягдлын худалдааг хязгаарлахад чиглэгдэх ёстой. Түүхий нүүрсийг хязгаарлалтын бүсээс гадуур хаа сайгүй худалдаж авах боломжтой байгаа учраас өнөөгийн нөхцөл байдалд албадан хэрэгжүүлэх арга хэмжээг худалдаанд чиглүүлэхэд хүнд байна. Цэвэр түлшний хөтөлбөрийн цар хүрээ өргөжөөд ирэхээр энэ арга хэмжээ чухал болно. Тэр үед нийслэлийн МХГ худалдаанд хийх шалгалтыг долоо хоног тутам явуулах хэрэгтэй.

Авч хэрэгжүүлэх гол арга хэмжээ

- 6а** Засгийн газар түүхий нүүрсний хоригийн хэрэгжилтийг хангахын тулд үйлдвэрлэгчдийн хүчин чадлыг бодитойгоор урьдчилан тооцоолсны үндсэн дээр 2013-2014 оны цэвэр түлш хэрэглэх үндсэн бүсийн хэмжээг шинэчлэн тогтоох
- 6б** Дугуй, хуванцар болон бусад хог хаягдал шатаах нь эрүүл мэндэд ямар хор холбогдолтойг гэр хорооллын иргэдэд ухуулж таниулах мэдээлэл, сурталчилгааны кампанит ажил зохион байгуулах
- 6в** Цэвэр түлш хэрэглэх үндсэн бүсэд дугуй, аюултай хог хаягдал шатаах хоригийг хэрэгжүүлэх тусгайлсан дүрэм журам боловсруулж мөрдүүлэх
- 6г** Цэвэр түлшний нийлүүлэлт үндсэн бүсийн хэрэглэгчдэд өвлийн турш хүрэлцэхүйц хэмжээнд болсны дараа түүхий нүүрс, хог хаягдал шатаах хоригийн хэрэгжилтийг хянан шалгаж, зөрчил гаргасан айл өрхийг торгох арга хэмжээ авч хэрэгжүүлэх

7 Албадлагын стратегийг хэрэгжүүлэх

Түүхий нүүрс, хог хаягдал шатаах хоригийг мөрдүүлэх ажлыг хэрэгжүүлэхийн тулд одоо ажиллаж буй бүтэц зохион бйагуулалтыг өөрчлөх шаардлага байхгүй (Зураг 1). Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хороо улсын түвшинд энэ ажлыг уялдуулан зохицуулах үүрэгтэй. Торгуулийн орлого цуглуулах үүргийг төрийн албан хаагч бус, иргэдийн төлөөлөл болох хэсгийн ахлагчид гүйцэтгэсэнээс татварын байцаагч юмуу мэргэжлийн хяналтын байцаагч энэ ажлыг хийх нь зүйтэй. Харин хэсгийн ахлагчид нь журам дүрэм мөрдөгдөж буй эсэхэд мониторинг хийж, иргэдийн мэдээ, мэдээллийг сайжруулах үүрэгтэй байх хэрэгтэй. Төсөв нь цэвэр түлшний хөтөлбөрийн нэгдсэн төсөвт тусгагдаж, ЦАС-гаас санхүүжнэ. Стратегийг хэрэгжүүлэхийн тулд ЦАС-гаас цэвэр түлшний хөтөлбөрийн үйл ажиллагаанд оролцдог ажилтнуудын ажил үүргийн тодорхойлолтонд энэ талын үүргийг тодорхой тусгаж өгөх шаардлагатай. Албадлагын стратеги болон түүнийг хэрэгжүүлэх бүтэц зохион байгуулалтыг хөтөлбөрт оролцогч талуудад тодорхой тайлбарлан таниулах хэрэгтэй бөгөөд НАЧА-гийн нэг албан хаагч нь мэдээллээр хангах үүрэгтэй ажиллавал зохино.

Зураг 1: Цэвэр түлш хэрэглэх үндсэн бүсэд бохирдуулагч бодис шатаах хоригийг мөрдүүлэх ажлыг хэрэгжүүлэх бүтэц



8 Сургалт

Улаанбаатар Цэвэр агаарын санаачлага-2 төслийн хүрээнд ажлийн даалгаврын 3.6.3-д заасны дагуу доорхи үднэсэн гурван ажлыг гүйцэтгэх үүрэгтэй. Үүнд

1. Зөвлөх баг нь хэрэгжүүлэх нэгжид зориулан сургалтын хөтөлбөр боловсруулна.
2. Сургалтын хөтөлбөрийн ерөнхий зураглалыг гаргана.
3. Сургалтыг тухайн нэгжийн боловсон хүчинтэй хамтран гүйцэтгэнэ гэж заасан.

Энэхүү ажлын хүрээнд төслийн Олон улсын болон Үндэсний зөвлөх хоёр хамтран сургалтуудыг доорхи хуваарийн дагуу явуулсан.

Зохих бэлтгэлийг ханган сургалтыг 1-р сарын 17-ноос 3-р сарын 7 хүртэл нийт дөрвөн удаагийн сургалтыг холбодгох талуудад явуулсан. Эдгээр сургалтанд БОНХЯ, МХЕГ, ЦАС, АББҮХ, НАЧА болон дүүрэг, хороо, хэсэг, борлуулагч нарын төлөөлөл албан хаагчид энэхүү сургалтанд оролцлоо. Сургалтанд төслийн хуулийн мэргэжилтэн Б.Цэцэнбилэг болон Бодлогын зөвлөх Онно вандэн Хивэл нар сургагч багшаар ажиллаа.

8.1 Сургалтын бэлтгэл ажил

Сургалтын бэлтгэл ажлын хүрээнд сургалтын агуулгыг оновчтой болгох, цэвэр түлшний түгээлтийн үйл ажиллагаанд бий болж байгаа бодит хүндрэл бэрхшээл дээр тулгуурлан сургалтын хөтөлбөрийг боловсруулахыг эрмэлзсэн бөгөөд сургалтад өмнө нь боловсруулсан түлшний нийлүүлэлт, хадгалалт зэрэг харилцаанд хэрэглэгдэж байсан гэрээний заалтуудаас жишээ болгон ашиглаж оруулсан болно.

Ийнхүү сургалтын хэрэгцээг тодорхойлсны дагуу:

- Боловсруулсан түлшний нийлүүлэлт, тээвэрлэлт, хадгалалтад гарч болох зөрчлүүдийг тодорхойлох
- Зөрчлийг шийдвэрлэх арга замууд
- Сургалтад оролцогчдод ойлгомжтой болгох зорилгоор өмнө нь боловсруулсан түлшний нийлүүлэлт, хадгалалт зэрэг харилцаанд хийгдэж байсан гэрээний заалтуудад дүн шинжилгээ хийх
- Хариуцлага тооцох, албадлага хэрэгжүүлэх эрх зүйн боломж арга замууд зэрэг сэдвийн хүрээнд сургалтыг зохионы байгуулсан болно.

Сургалтыг танхимын болон тушлага судлах гэсэн хоёр хэсэгт хуваасан ба танхимын сургалтын хүрээнд багш нар нь төслийн судалгааны үр дүнг тайлбарласан (Хавсралт 2-ыг үзнэ үү) бол тургшлага судлах, үзүүлэн таниулах ажлын хүрээнд борлуулах цэг, боловсруулсан түлшний чанарын шинжилгээ хийдэг голлох лабораториудад зочлон тэдний үйл ажиллагаатай танилцуулсан.

8.2 Сургалтын агуулга

Сургалтын танилцуулга нь:

- Олон улсын туршлага
- Албадлагын талаарх ерөнхий ойлголт,
- Түлшний нийлүүлэлтийн сүлжээнд албадлага хэрэгжүүлэх гэсэн 2 үндсэн сэдэвтэй боловсруулагдсан.

8.2.1 Олон улсын туршлага

Төслийн холбогдох талуудын хүсэлтийн дагуу Монгол оронд жишиг болохуйц Ирланд улсын агаарын бохирдолтой тэмцэж байгаа жишээг оруулсан.

Агаарын бохирдолтой тэмцэж буй өнөөгийн Монгол орны туршлагатай харьцуулахад Ирланд улс нь энхээр чиглэлд их уян хатан, урт удаан хугацааны аажим бодлого баримтласан. 1990 онд анх Ирланд нь зөвхөн цэвэр агаарын бүсийг байгуулан энэхүү бүсэд түүхий нүүрсийг сурталчлах, худалдах, зарах зэрэг бүхэл ханган нийлүүлэлтийн замуудыг хориглосон бөгөөд харин тухайн бүсийн хэрэглэгчдийн түүхий нүүрс түлэх эрхийг хорилгүй нээлттэй хэвээр үлдээсэн. 23 жилийн дараа буюу зөвхөн энэ жилээс эхлэн аливаа өрх, иргэний түүхий нүүрсийг хэрэглэх эрхийг хориглосон ба зөрчсөн тохиолдолд 1000-5000 еврогоор торгох шийдвэр гаргажээ.

Ирланд нь антрацит (Anthracite)⁹ төрлийн нүүрсийг хязгаарлалтын бүсэд зөвшөөрдөг ба энэ төрлийн байгалиасаа аливаа бохирдол, утаа багатай нүүрсийг утаагүй түлшинд тооцох боломж Монгол оронд байгаа талаар сургалтанд оролцогчидтой зөвлөлдсөн.

Бас нэгэн давуу тал нь Ирланд даяар гол эрдсэлтэй газруудыг хамарсан агаарын бохирдлыг хэмжин мэдээлдэг автомат тоног төхөөрөмжүүдийн сүлжээ юм. Энэхүү мэдээлэл цаг тутам төв цахим хуудсанд ачаалагдан олон нийтэд хүрч байдаг. Энэ нь Европын холбооны улсын нэгдсэн стандарт юм.

8.2.2 Албадлагын талаарх ерөнхий ойлголт сэдвийн хүрээнд

Эрх зүйн ойлголтын албадлагын арга хэмжээний тухай ойлголт, хэрэглэх нөхцөлийн талаар ерөнхий ойлголт өгөхийг зорьсон.

Хууль зүйн хүрээнд хэрхэн тодорхойлж болох, албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэхэд зайлшгүй байх ёстой нөхцөлүүд, тэдгээрийн үндэслэл шалтгааны талаар сургалтын явцад тайлбарласан юм.

Түлшний нийлүүлэлтийн сүлжээнд албадлага хэрэгжүүлэх сэдвийн хүрээнд

Энэхүү сэдвийн хүрээнд боловсруулсан түлш нийлүүлэлт, тээвэрлэлт, хадгалалт зэрэг харилцаа тус бүрийн харилцаанд гарч болох зөрчлүүд, түүнийг шийдвэрлэх арга замын талаар тодорхой ойлголт өгөхийг зорьсон.

8.2.3 Боловсруулсан түлш нийлүүлэх

Боловсруулсан түлш нийлүүлэх харилцаанд гарч болох зөрчлүүдийг тодорхойлсон:

Үүнд:

- Түлшний чанар
- Түлшний нийлүүлэлтийн хэмжээ
- Түлш нийлүүлэх хугацаа
- Сав баглаа боодол

Энэхүү зөрчлүүд тус бүрийг зохистой шийдвэрлэхийн тулд гэрээг хэрхэн хууль зүйн үндэслэлтэй байгуулах, гэрээний зүйл заалт нөхцөлийг хэрхэн тодорхойлвол зохих талаар боловсруулсан түлшний нийлүүлэлтэд 2011 буюу 2012 онуудад боловсруулсан түлшний нийлүүлэлтэд хийгдэж байсан гэрээний заалтуудыг жишээ болгон сургалтад ашигласан юм.

Ийнхүү гэрээний зүйл заалтыг жишээ болгон ашиглахдаа гэрээний нөхцөлийг тодорхойлоход анхаарах зүйлүүд, тодорхойгүй заалтаас гарч болох хүндрэл, цаашид анхаарах зүйлүүдийн талаар ойлголт өгөхийг зорьсон.

⁹ Хагас антрацит болон антрацит (*Anthracite*) - хамгийн их хувирсан нүүрс ба утаа бохирдолгүй.

Мөн хууль болон гэрээний үндсэн дээр үүрэг гүйцэтгээгүй этгээдэд хэрхэн хариуцлага тооцох, хариуцлага тооцох үндэслэл, шийдвэрлэх эрх бүхий этгээдийн талаар тайлбарласан болно.

Өөрөөр хэлбэл түлшийг гэрээнд заасан хэмжээнд болон гэрээнд заасан хугацаанд нийлүүлээгүй тохиолдолд ямар арга хэмжээ авч болох, өмнө хийгдэж байсан гэрээнүүдэд энэ талаар хэрхэн зохицуулж байсан, энэхүү зохицуулалтын дагуу шийдвэрлэхэд ямар хүндрэл гарч болох, цаашид уг асуудлыг зохицуулахын тулд гэрээний нөхцөлийг хэрхэн тодорхойлох талаар ойлголт өгөхийг зорьсон юм.

8.2.4 Боловсруулсан түлш хадгалах

Боловсруулсан түлш хадгалах харилцаанд гарч болох зөрчлүүдийг тодорхойлсон:

- Агуулахын чанарын шаардлага
- Хадгалагдаж буй түлшний харуул хамгаалалт
- Аюулгүй байдал

Энэ дэд сэдвийн хүрээнд мөн эдгээр зөрчлүүд тус бүрийг гэрээнд хэрхэн тусгавал зохих талаар өмнө нь хийгдэж байсан гэрээнүүдэд хэрхэн зохицуулагдсан зүйл заалтыг жишээ болгон сургалтын хүрээнд тайлбарласан бөгөөд боловсруулсан түлшийг агуулахад хадгалахад агуулах түрээслэх гэрээ хийж байгаа бөгөөд энэхүү гэрээг байгуулахад анхаарах зүйлүүд, гэрээний дагуу авч болох арга хэмжээнүүд, харуул хамгаалалтын асуудлыг хэрхэн шийдвэрлэх зэрэг нөхцөл байдлуудын талаар ойлголт өгөхийг зорьсон болно.

Одоогийн байдлаар агуулахад тавих стандартийг холбогдох хууль тогтоомжид хангалттай зохицуулаагүй, бөгөөд “Боловсруулсан түлш нөөцлөх, дүүрэг, хороо, иргэдэд хүргэх журам”-ын 2.7-д **“стандартын шаардлага хангасан /дэд бүтэц сайтай, төмөр зам болон авто замтай, байнгын харуул хамгаалалттай, цас борооны ус нэвтрэхгүй битүүмжлэл сайтай/...**” гэж зохицуулсан нь хангалттай зохицуулалт болж чадахгүй байгаа юм. Иймээс гэрээнд тодорхой заалт оруулах, үл хөдлөх эд хөрөнгө түрээслэх гэрээний анхан шатны шаардлагуудын талаар авч үзсэн юм.

8.2.5 Боловсруулсан түлшний тээвэрлэлт

- Тээвэрлэх тээврийн хэрэгсэлд тавигдах шаардлага
- Тээвэрлэлтийн явцад бараа гэмтэх, гээгдэх, чанараа алдах

Тээвэрлэлтийн явцад бараа гэмтэх чанараа алдах тохиолдолд хуулийн дагуу авах арга хэмжээний талаар авч үзсэн бөгөөд үүнд:

Авах арга хэмжээ:

- Ачаа хүлээн авагч ачааг хүлээн авахдаа тээвэрлэгчтэй хамт түүнийг шалгаагүй, эсхүл алдагдсан, дутсан ачааны болон учирсан хохирлын талаар ямар нэгэн шаардлага тээвэрлэгчид гаргаагүй бол эсрэгээр нотлогдох хүртэл ачаа хүлээн авагч ачааг **дагалдах бичигт** заасан байдлаар хүлээн авсанд тооцно.
- Ачаа хүлээн авагч ачааны илэрхий гэмтэл, дутагдлын талаархи шаардлагыг ачаа хүлээн авсан өдөр, харин далд дутагдалтай холбоотой шаардлагыг ачааг хүлээн авсан өдрөөс **хойш 7 хоногийн** дотор бичгээр тээвэрлэгчид гаргана.

Мөн Тээвэрлэгч **ачааг хүлээн авснаас хойш хүлээлгэн өгөх** хүртэлх хугацаанд ачаа алдагдсан, дутсан, гэмтсэн, түүнчлэн тээвэрлэлтийн хугацаа хоцроосны хариуцлагыг бүхэлд нь буюу хэсэгчлэн хариуцах талаар болон бусад тээвэрлэлтийн гэрээний харилцаанд ач холбогдол бүхий, анхаарвал зохих зохицуулалтын талаар тайлбарласан болно.

9 Хавсралт

Хавсралт 1: Холбогдох эрх зүйн актын нэрс

1. ХУУЛЬ

- 1.1 Иргэний хууль
- 1.2 Агаарын тухай хууль
- 1.3 Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль

2. ТОГТООЛ/ БУСАД ЖУРМУУД

- 2.1 Монгол Улсын Их Хурлын Тогтоол #11, 2011.02.10
- 2.2 Нийслэлийн Засаг даргын захирамж #351, 2011.04.22
- 2.3 Хязгаарлалтын бүс тогтоохтой холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай, Байгаль орчин аялал жуучлалын сайд болон Нийслэлийн засаг даргын хамтарсан тушаал, захирамж, #А11/361, 2011.04.22
- 2.4 Эрчим хүчний хэмнэлттэй зуухыг нийлүүлэх, борлуулах талаар #11/038
- 2.5 Журам батлах тухай 11/04
- 2.6 Авто тээврийн хэрэгслийн бохирдлыг бууруулах арга хэмжээний тухай #11/05
- 2.7 Агаарын чанарыг сайжруулах бүсэд авах арга хэмжээний тухай #11/06
- 2.8 Төвлөрсөн дулаан хангамжинд холбох тухай #11/07
- 2.9 Сайжруулсан зууханд татаас нэмж олгох тухай #11/08
- 2.10 Журам батлах тухай #131, 2011.09.07
- 2.11 Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах хязгаарлалтын бүсэд иргэн, аж ахуй нэгж, байгууллагын дагаж мөрдөх журам
- 2.12 Боловсруулсан түлш нөөцлөх, дүүрэг, хороо, иргэдэд хүргэх журам
- 2.13 Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах хязгаарлалтын бүсэд хяналт тавьж ажиллах орон тооны бус байцаагчийн ажиллах журам
- 2.14 Шахмал түлшний стандарт
- 2.15 “Агаарын чанарыг сайжруулах бүс дэх түүхий нүүрсийг хязгаарлах үндсэн бүсэд орших айл өрхийг боловсруулсан түлшээр хангах нөөц бүрдүүлэхтэй холбогдуулан урьдчилгаа санхүүжилт олгох тухай журам”

Хавсралт 2: Сургалтын илтгэлүүд

<p>Түлшний нийлүүлэлтийн сүлжээнд албадлага хэрэгжүүлэх</p> <ul style="list-style-type: none"> Нийлүүлэлтэд гарч болох зөрчлийг тодорхойлох нь: <ul style="list-style-type: none"> Түлшний чанар Түлшний нийлүүлэлтийн хэмжээ Түлш нийлүүлэх хугацаа Сав баглаа бөөдөл 	<p><u>"Улаанбаатар Цэвэр Агаар Санаачлага II ve" төсөл:</u></p> <p>"Боловсруулсан түлшний хууль эрх зүйн орчин, холбогдох дүрэм, журам"</p> <p>Хэрэгжүүлэгч: Еврокомсент Инт.Монголд Туслам гүйцэтгэгч: Идэрэв Хөдөлгөөн Хөдөл ТББ, Импалкан Барристерс & Солжикторс ООХ (MCS хуулийн фирм)</p> <p>Улаанбаатар хот 2013 он</p>
<p>Түлшний нийлүүлэлтийн сүлжээнд албадлага хэрэгжүүлэх</p> <ul style="list-style-type: none"> Түлшний чанар: <ul style="list-style-type: none"> Түлшинд тавигдах MNS 5679; 2011 стандарт батлагдсан байна. Түлш нийлүүлэх гэрээний 4.3 "Аж ахуйн нэгжүүдээс түлшний шинжилгээний дүнг НАЧА шаардаж авах эрхтэй." гэж заасан байна. Гэрээний заалтын талаар: <ul style="list-style-type: none"> "Аж ахуйн нэгжүүд" "Шинжилгээний дүнг" "НАЧА" "шаардаж авах эрхтэй" 	<p>Албадлагын арга хэмжээний ерөнхий ойлголт</p>
<p>Түлшний нийлүүлэлтийн сүлжээнд албадлага хэрэгжүүлэх</p> <ul style="list-style-type: none"> Авах арга хэмжээ: <ul style="list-style-type: none"> Гэрээний дагуу авах арга хэмжээ <ul style="list-style-type: none"> "Нийлүүлэгч талаас стандартын шаардлага хангаагуй бүтээгдэхүүн нийлүүлснийг захиалагч тал бичгээр мэдээдсэн тохиолдолд санхүүжүүлэгч талаас санхүүжилтийг бүрэн зогсоох эрхтэй" /гэрээний 5.2.4/ 	<p>Түлшний нийлүүлэлтийн сүлжээнд албадлага хэрэгжүүлэх</p> <p>Түлшний түгээлт:</p>

Түлшний нийлүүлэлтийн сүлжээнд албадлага хэрэгжүүлэх

- Сав, баглаа, боодол
- Гэрээний 5.1.10 "сав, баглаа боодол дээр түлшний хэв загварыг харуулсан зураг бүтээгдэхүүний нэр, жин, үйлдвэрлэгчийн нэр, хаягыг тодорхой бичсэн байна."
- "Боловсруулсан түлш нөөцлөх, дүүрэг, хороо, иргэдэд "хүргэх журам"-ын 2.9-д "Түлшний жижиглэнгийн сав, баглаа боодлыг зориулалтын дагуу чанартай материалаар хийж, түлшний хэв загварыг харуулсан зураг болон бүтээгдэхүүний нэр, жин, үйлдвэрлэсэн он, сар, өдөр, үйлдвэрлэгчийн нэр, хаяг, хадгалалт, хэрэглэх зааврыг тодорхой бичиж, гарах зардлыг түлш үйлдвэрлэгч аж ахуйн нэгж байгууллага өөрсдөө хариуцах бөгөөд энэ нь гурвалсан гэрээнд батлагдсан түлшний борлуулалтын үнэд орж тооцогдсон байна."

Түлшний нийлүүлэлтийн сүлжээнд албадлага хэрэгжүүлэх

- Хуулийн дагуу авч болох арга хэмжээ:
- Үүргээ гүйцэтгэх нэмэлт хугацаа тогтоох
- Гэрээнээс татгалзах (Иргэний хуулийн 225.1)
- Чанарын шаардлага хангаагүй түлшний улмаас иргэн аж ахуй нэгж байгууллагад хохирол учирсан бол хохирол нөхөмжлөх
- Чанарын доголдлыг арилгуулахыг шаардах (Иргэний хуулийн 264.1)
- Хариуцлага тооцуулахаар эрх бүхий байгууллагад мэдэгдэх

Түлшний нийлүүлэлтийн сүлжээнд албадлага хэрэгжүүлэх

- Авах арга хэмжээ
- Агуулахаас гаргасан түлшний тээвэрлэлтийн явцад шуудай задрах, түлш хэв алдагдах гэх мэт эрсдэлийг тээвэрлэгч компани Захиалгачийн өмнө хариуцна.
(Түлш нийлүүлэх гэрээний 5.3.5)
- шуудай задрах
- тээвэрлэгч компани
- Гэрээнд өөр хариуцлага тооцох заалт байхгүй.
- Хуульд зааснаар бүтээгдэхүүний чанарын доголдол гэж үзэх /Чанарыг тодорхойлох/

Түлшний нийлүүлэлтийн сүлжээнд албадлага хэрэгжүүлэх

- Бүтээгдэхүүн нийлүүлэлт, гэрээний маргаан шийдвэрлэх арга зам
- Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төргүүлэгчдийн 2011 оны 09 дугаар сарын 07-ны өдрийн 131 тоот тогтоолоор баталсан "Боловсруулсан түлш нөөцлөх, дүүрэг, хороо, иргэдэд "хүргэх журам" –ын 7 дугаар зүйлийн 7.1-д "Түлш нөөцлөх явцад гарсан түлшний чанар, стандарт, жин, хэмжээ, санхүүжилттэй холбоотой гарсан маргааныг Нийслэлийн агааран чанарын алба шийдвэрлэх"-ээр заажээ.
- Шийдвэрлэх ажиллагаа
- Эрх хэмжээ
- Шийдвэр хүчин төгөлдөр байх
- Шийдвэрт гомдол гаргах эрх зүйн боломж

Түлшний нийлүүлэлтийн сүлжээнд албадлага хэрэгжүүлэх

- Анз
- Төргууль
- Үүргээ гүйцэтгээгүй буюу зохих ёсоор гүйцэтгээгүй тал нь төлөхөөр хууль болон гэрээнд урьдчилан тодорхой хэмжээгээр заасан, өсхүл гүйцэтгээгүй буюу зохих ёсоор гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн тодорхой хувиар тогтоосон анаыг төргууль гэнэ.
(Иргэний хуулийн 232.5)
- Алданга
- Хууль болон гэрээнд заасан хугацаа хэтрүүлсэн тал нь хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0,5 хувиас хэтрэхгүй хэмжээгээр төлөхөөр тогтоосон анаыг алданги гэнэ.
(Иргэний хуулийн 232.6)

Түлшний нийлүүлэлтийн сүлжээнд албадлага хэрэгжүүлэх

- **Агуулахын чанарын шаардлага**
 - Боловсруулсан түлш нөөцлөх, дүүрэг, хороо, иргэдэд хүргэх журам"-ын 2.7-д **"стандартын шаардлага хангасан /дэд бүтэц сайтай, төмөр зам болон авто замтай, байнгын харуул хамгаалалттай, цаас борооны ус нэвтрэхгүй битүүмжлэл сайтай..."**
 - **Стандартын шаардлага хангасан**
 - **Тодорхойлох эрх б үхий этгээд**

Түлшний нийлүүлэлтийн сүлжээнд албадлага хэрэгжүүлэх

- "Агаарын чанарыг сайжруулах бүс дэх түүхий нүүрсийг хягаарлах үндсэн бүсэд орших айл өрхийг боловсруулсан түлшээр хангах нөөц бүрдүүлэхтэй холбогдуулан урьдчилгаа санхүүжилт олгох тухай журам"-ын 6.1-д "Нөөцийн түлшийг хүлээн авах, хадгалах, борлуулах үйл ажиллагаанд **Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар, дүүрэг хороодын Засаг дарга, хорооны Агаарын чанарын хяналтын ажилтнууд болон "Цэвэр агаарын сан"** хяналт тавьж ажиллана."

Түлшний нийлүүлэлтийн сүлжээнд албадлага хэрэгжүүлэх

Авах арга хэмжээ

Гэрээний дагуу авах арга хэмжээ

- Агуулахын битүүмжлэл алдагдсан тохиолдолд учирсан хохирол арилгах /агуулах түрээслэх гэрээний 5.3/

Хуулийн дагуу авах арга хэмжээ

- Гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд хохирол нэхэмжлэх

Түлшний нийлүүлэлтийн сүлжээнд албадлага хэрэгжүүлэх

Маргааныг шүүх шийдвэрлэх

Талууд харилцан зөвшилцөж маргааныг шийдвэрлэж чадаагүй тохиолдолд шүүхээр маргааныг шийдвэрлүүлно.

Шүүхээр шийдвэрлүүлэхдээ санхүүжүүлэгч, захиалагч өөрт учирсан хохирлоо давхар нохойлж эрхтэй.

Хохирол тооцох:

- "Үүрэг гүйцэтгүүлэгчээс гарсан зардал, эд хөрөнгийн алдагдал буюу гэмтэл, үүрэг гүйцэтгэм үүргээ гүйцэтгэсэн бол үүрэг гүйцэтгүүлэгчид зайлшгүй өрөх байсан орлогыг хохиролд тооцно." (Иргэний хуулийн 227.3)

Түлшний нийлүүлэлтийн сүлжээнд албадлага хэрэгжүүлэх

- **Хадгалагдаж буй түлшний харуул хамгаалалт**
 - Гэрээнд Түрээслүүлэгч харуул хамгаалалт бүрэн бүтэн байдлыг хариуцах заалт байхгүй
 - Харуул хамгаалттай гэрээ байгуулах
 - Хариуцлага тооцох зохицуулалт оруулах

Түлшний нийлүүлэлтийн сүлжээнд албадлага хэрэгжүүлэх

- **Түлш хадгалах**
- **Зөрчлийг тодорхойлох нь:**
 - Агуулахын чанарын шаардлага
 - Хадгалагдаж буй түлшний харуул хамгаалалт
 - Аюулгүй байдал

Түлшний нийлүүлэлтийн сүлжээнд албадлага хэрэгжүүлэх

• Шүүхээр шийдвэрлүүлэх

- Тээвэрлэлтийн гэрээний маргааныг шүүхээр шийдвэрлүүлэхэд хөөн хэлэлцэх хугацааг зайлшгүй анхаарч үзэх шаардлагатай.

Тээвэрлэлтийн гэрээнээс үүсэх швардах эрхийн хөөн хэлэлцэх хугацааг нэг жил, санавтай буюу илт болгоомжгүй үйлдлийн улмаас хоёрлол учирсан бол хөөн хэлэлцэх хугацаа гурван жил байдаг.

(Иргэний хуулийн 395 дугаар зүйлийн 395.1 дэхь заалт)

Түлшний нийлүүлэлтийн сүлжээнд албадлага хэрэгжүүлэх

• Түлш тээвэрлэх Зөрчлийг тодорхойлох

- Тээвэрлэх тээврийн хэрэгсэлд тавигдах шавардлага
- Тээвэрлэлтийн явцад бараа гэмтэх, гээгдэх, чанараа алдах

Анхаарал тавьсанд баярлалаа

Холбоо барих цахим шуудан: info@imbs.mn

Түлшний нийлүүлэлтийн сүлжээнд албадлага хэрэгжүүлэх

• Тээвэрлэх тээврийн хэрэгсэлд тавигдах шавардлага

Түлшийг тээвэрлэх тээврийн хэрэгсэлд тавигдах шавардлагыг тодорхойлсон эрх зүйн акт байхгүй

Тээвэрлэлтийн явцад бараа гэмтэх чанараа алдах

Тээвэрлэгч ачааг хүлээн авснаас хойш хүлээлгэн өгөх хүртэлх хугацаанд ачаа алдагдсан, дутсан, гэмтсэн, түүнчлэн тээвэрлэлтийн хугацаа хоцроосны хариуцлагыг бүхэлд нь буюу хэсэгчлэн хариуцна

Түлшний нийлүүлэлтийн сүлжээнд албадлага хэрэгжүүлэх

• Авах арга хэмжээ

- Ачаа хүлээн авагч ачааг хүлээн авахдаа тээвэрлэгчтэй хамт түүнийг шалгажгүй, эсхүл алдагдсан, дутсан ачааны болон учирсан хожирлын талаар ямар нэгэн шавардлага тээвэрлэгчид гаргаагүй бол эсрэгээр нотлогдох хүртэл ачаа хүлээн авагч ачааг дагалдах бичигт заасан байдлаар хүлээн авсанд тооцно.

- Ачаа хүлээн авагч ачааны илэрхий гэмтэл, дутагдлын талаархи шавардлагыг ачаа хүлээн авсан өдөр, харин далд дутагдалтай холбоотой шавардлагыг ачааг хүлээн авсан өдрөөс хойш 7 хоногийн дотор бичгээр тээвэрлэгчид гаргана.

Хавсралт 3: Нэмэлт мэдээлэл

Гэрээний нэр	Улаанбаатар Цэвэр агаарын санаачлага – II үе – Төслийн хяналт удирдлага
Тайлангийн нэр	Цэвэр түлшний хөтөлбөрийг албадан хэрэгжүүлэх стратеги, сургалт (3.6.1 – 3.6.3)
Захиалагч	Байгаль орчин, ногоон хөгжлийн яам
Гэрээний дугаар	C22384/EBSF-2009-09-117/01

Захиалагчийн холбогдох мэдээлэл

БОНХЯ,
Тогтвортой хөгжил, стратеги төлөвлөлтийн газар
Засгийн газрын байр II
Нэгдсэн Үндэстний гудамж 5/2
Улаанбаатар хот-210646
Монгол улс

Зөвлөх

Евроконсалт мотт макдоналд

Шуудангийн хайрцаг 441
6800 АК Арнхем
Нидерланд улс

Утас:+31 (0) 26 357 7111, **Факс:** +31 (0) 26 357 7577

И-мэйл:euroconsult@mottmac.nl,

вeб хуудас:www.euroconsult.nl

Гэрээний менежер/
Төслийн захирал

Каролин ла Чапелл
И-мэйл: caroline.lachapelle@mottmac.nl

Багийн ахлагч/
Төслийн менежер

Пиет де Вилдт
И-мэйл: piet.wildt@mottmac.nl